



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 2

- Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль
- Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль
- Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зөрчих, цагаачлах тухай хууль
- Хууль хүчингүй болсонд төөцөх тухай хууль
- Дархааны өлдмөл хэмсгөл овчирч сөргийлэх тухай хууль

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар

1994 он

## УНШИГЧ ТАНЫ СОНОРТ

Монгол Улсын хууль тогтоомжууд, Ерөнхийлөгчийн зарлиг захирамжууд, Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлт, тогтоолууд, Засгийн газраас гаргаж буй нэг чухал тогтоол, шийдвэрүүд болон хуулиудын таларх Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбар, тогтоолуудыг эмхтгэн хэвлэдэг төрийн албан ёсны хэвлэл «ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ» нь уншигч Таны найдвартай туслагч байх болно. 1994 онд сар бүр гарна. Нэг дугаарын үнэ 200 төгрөг.

Сэтгүүлийн үнийг нийтийн тогтмол хэвлэлийн захиалгаар нийслэлд болон аймаг, хот дахь «Алаг дэлхийн сонин» компанийн 200002 дансанд шилжүүлнэ. Захиалгыг улирлаар, хагас бүтэн жилээр хийх боломжтой.

«ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ» сэтгүүлээ өргөнөөр захиалагтун!



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

(ХУУЛЬ, ТОГТООЛ, ЗАРЛИГ,  
ШИЙДВЭР, НИЙТЛЭЛ—ХУУЛИЙН  
ТАЙЛБАР)

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар

№ 1994 оны 2 сар

№ 2 (21)

## ГАРЧИГ

Хуудасны дугаар

### I. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- |  |     |
|--|-----|
| 1. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай                                   | 77  |
| 2. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай                               | 88  |
| 3. Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зөрчих,<br>цагаачлах тухай | 100 |
| 4. Хууль хүчингүй болсонд тооцох тухай                                   | 105 |
| 5. Дархлааны олдмол хомсдол өнчинг сэргийлэх тухай                       | 106 |

### II. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛЫН ТОГТООЛ

- |   |     |
|---|-----|
| 6. Монгол Улсын иргэн хувийн хэргээр гадаадад зөрчих,<br>цагаачлах тухай болон Гадаадын иргэний эрх зүйн байдлын<br>тухай Монгол Улсын хуулийг хэрэгжүүлэх зарим<br>арга хэмжээний тухай № 99 | 112 |
| 7. Дархлааны олдмол хомсдол өнчинг сэргийлэх тухай<br>хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга<br>хэмжээний тухай № 100   | 113 |
| 8. Олон улсын гэрээний тухай Монгол Улсын хууль батлагд-<br>сантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай № 101   | 114 |

9. Монголбанкны 1994 оны орлого, зарлагын төсвийг битлэх тухай № 01	115
10. «1 төгрөг», «10 төгрөг», «20 төгрөг», «10 мянган», «20 мянган», «50 мянган»-ийн дэвсгэртнийг хууль ёсны тнлборрийн хэрэгсэлд тооцох, гүйлгээнд гаргахыг зовшоорох тухай № 02	116
11. Төсөл буцаах тухай № 03	117
12. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай № 04	118
13. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тухай № 05	119

### III. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЯЛӨГЧИЙН ЗАРЛИГ

14. Ишдогийн Очирбаад дипломат цол олгох тухай № 128	120
15. Лувсандоржийн Даваагэвт дипломат цол олгох тухай № 129	121
16. Агваандоржийн Цолмонд дипломат цол олгох тухай № 130	122
17. Дашдаваагийн Чулуундоржид дипломат цол олгох тухай № 131	123

### IV. ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ

18. Монгол Улсын Шүүхийн тухай хуультай холбогдсон маргааныг хянан хэлэлцсэн тухай № 01	124
---	-----

### V. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

19. Статистикийн ажлын талард авах зарим арга хэмжээний тухай № 01	130
--	-----

### VI. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ

20. Шүүхийг мэргэжлийн удирдалгаар хангах журмын тухай № 55	137
---	-----

### VII. НИЙТГЭЭЛ, ТАЛБАР ЗӨВЛӨМЖ

21. Банкны хуульд зарим нэмэлт бөрчлөлт оруулах тухай хуулийн талаар	144
22. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай Монгол улсын хуулийн талаар	147
23. Монгол Улсын иргэн гэдгээд хувийн хэргээр зөрчих, цагаачлах тухай хуулийн талаар	150

МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ

1993 оны 12 дугаар  
сарын 20-ны өдөр

Улаанбаатар  
хот

ХОТ, ТОСГОНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгон, тэдгээрийн нийгэм, эдийн засгийн үндэс, удирдлагын үйл ажиллагааны зарчим, тогтолцоо, бүрэн эрхийг тодорхойлож, хот, тосгоны удирдлагаас засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага болон аж ахуйн нэгж, байгууллага, оршин суугчидтай харилцах харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Хот, тосгон

1. Хот, нь 15000-аас доошгүй оршин суугчтай, тэдгээрийн дийлэнх хувь нь голлон үйлдвэр, үйлчилгээний салбарт ажилладаг, хот бүрдүүлэгч дэд бүтэц хөгжсөн, өөрийн удирдлага бүхий төвлөрсөн суурин газар мөн.

2. Тосгон нь 500—15000 оршин суугчтай, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, аялал жуулчлал, амралт, сувилал, тээвэр, худалдаа зэрэг салбарын аль нэг хөгжсөн, өөрийн удирдлага бүхий суурин газар мөн.

3. Улсын болон тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засаг, нийгмийн хөгжилд гүйцэтгэх үүрэг, ач холбогдлыг нь харгалзан шаардлагатай гэж үзвэл тосгоныг

хотод тооцох асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

**4 дүгээр зүйл.** Хотын зэрэглэл

1. Хот нь оршин суугчдын тоо, хот бүрдүүлэгч дэд бүтцийн хөгжлийн түвшин, улсын болон тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засаг, нийгмийн хөгжилд гүйцэтгэх үүргээс хамааран улсын буюу аймгийн зэрэглэлтэй байна.

2. 50000-аас дээш (шаардлагатай гэж үзвэл 50000 хүртэл) оршин суугчтай хотод улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд гүйцэтгэж байгаа үүрэг, хөгжилт, хот бүрдүүлэгч дэд бүтцийн хөгжлийн түвшинг харгалзан улсын зэрэглэл тогтоож болно.

3. Хотод улсын зэрэглэл тогтоох асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал, аймгийн зэрэглэл тогтоох асуудлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын өргөн мэдүүлснээр Засгийн газар тус тус шийдвэрлэнэ.

**5 дугаар зүйл.** Хот, тосгоны засаг захиргааны харьяалал

1. Хот, тосгон нь засаг захиргааны хувьд оршин байгаа тухайн аймаг, суманд харьяалагдана.

2. Хот, тосгоны эдэлбэр газар нь хэд хэдэн сумын нутаг дэвсгэрийг дамнан байрлаж болох бөгөөд шаардлагатай бол тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэст өөрчлөлт оруулах асуудлыг хууль тогтоомжид заасан журмаар шийдвэрлэнэ.

**6 дугаар зүйл.** Хот, тосгоны эдэлбэр газар

1. Хот, тосгон нь эдэлбэр газартай байна.

2. Хот, тосгонд эдэлбэр газар олгох, түүний хэмжээ, заагийг өөрчлөх асуудлыг хууль тогтоомжид заасан журмаар шийдвэрлэнэ.

**7 дугаар зүйл.** Хот, тосгоны аж ахуй

Хот, тосгоны аж ахуй нь оршин суугчдын нийгэм, эдийн засаг, ахуй, соёлын хэрэгцээг хангалтай холбогдсон үйлдвэр, үйлчилгээний газар, орон сууц, зам, тээвэр, холбоо, дулаан, усан хангамж, цэвэрлэх байгууламж болон хот ийгийн аж ахуй зэргээс тус тус бүрдэнэ.

**8 дугаар зүйл.** Хот, тосгоны хөрөнгийн сан

1. Хот, тосгон нь удирдлагын болон хөгжлийн санхүүгийн үндэс болсон хөрөнгийн сантай байна.

2. Улсын зэрэглэлтэй хотын хөрөнгийн сан нь улсын төвлөрсөн ба орон нутгийн төсвөөс, аймгийн зэрэглэлтэй хот, тосгоны хөрөнгийн сан нь тухайн орон нутгийн төсвөөс тэдгээрийн мэдээд хуваарилсан төсвийн хөрөнгө, түүнчлэн хот, тосгоны өөрийн мэдлийн аж ахуйгаас бий болсон орлого, гаднаад, дотоодын байгууллага, хувь хүмүүсээс өргөсөн хандив, буцалтгүй тусламж, бусад орлогоос бүрдэнэ.

## ХОЕРДУГААР БҮЛЭГ

### Хот, тосгоны удирдлага

9 дүгээр зүйл. Хот, тосгоны удирдлагын үндсэн зарчим

Хот, тосгоны удирдлага нь үйл ажиллагаандаа ардчилсан ёс, шударга ёс, хууль дээдлэх болон оршин суугчдын ашиг сонирхлыг төлөөлөх үндсэн зарчим баримтална.

10 дугаар зүйл. Хот, тосгоны удирдлагын тогтолцоо

1. Хот, тосгоны удирдлага нь захирагч, зөвлөлөөс бүрдэнэ.

2. Хот, тосгоны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан чиглүүлж зохион байгуулах үүргийг захирагч гүйцэтгэнэ.

3. Хот, тосгоны зөвлөлийг тухайн хот, тосгоны нийгэм, эдийн засагт нөлөө бүхий аж ахуйн нэгж, байгууллага болон захирагчийн ажлын албаны хүмүүсийг оролцуулан 5—11 хүний бүрэлдэхүүнтэйгээр захирагч байгуулна.

Хот, тосгоны зөвлөлийг захирагч тэргүүлнэ.

4. Аймаг, сум, багийн төв болох хот, тосгоны удирдлагын бүрэн эрхийг тухайн хот, тосгон оршин байгаа засаг захиргааны нэгжийн Засаг дарга хэрэгжүүлнэ.

5. 500 хүртэл хүн амтай сууринд оршин суугчдын нийгэм, ахуйн асуудлыг тухайн сууринд голлох аж ахуйн нэгжийн удирдлага, түүнчлэн харьяалах баг, сумын иргэдийн Нийтийн болон Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга тус тус шийдвэрлэнэ.

6. Хот, тосгоны захирагч нь ажлын албатай байна. Захирагчийн ажлын албаны бүтэн, орон тооны хязгаарыг Засгийн газраас нэгбүрчлэн буцау нэг маягаар тогтооно.

7. Энэ зүйлийн 4 дэх хэсэгт зассан тохиолдолд улсын зэрэглэлтэй хотын захирагчийн ажлын алба нь Засаг дар-

гийн ажлын албанаас тусдаа байх бөгөөд бусад хот, тосгоны захирагчийн ажлын алба нь нэг байж болно.

**11 дүгээр зүйл.** Хот, тосгоны захирагчийг сонгох зарчим

Энэ хуулийн 10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаас бусад тохнолдолд хот, тосгоны захирагчийг тухайн хот, тосгоны сонгуулийн эрх бүхий оршин суугчид нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, 4 жилийн хугацаагаар сонгоно.

**12 дугаар зүйл.** Хот, тосгоны захирагчид нэр дэвшүүлэх

1. Хот, тосгоны захирагчид тухайн хот, тосгоны оршин суугчдын Хурал, харьяалах засаг захиргааны нэгжийн иргэдийн Нийтийн болон Төлөөлөгчдийн Хурлаас нэр дэвшүүлнэ.

2. Тосгонд 100-аас доошгүй, хотод 500-аас доошгүй оршин суугчийн дэмжлэг авсан иргэн хот, тосгоны захирагчид биелэн нэрээ дэвшүүлж болно.

**13 дугаар зүйл.** Сонгууль эрхлэн явуулах

Хот, тосгоны захирагчийн сонгуулийг тухайн хот, тосгоныг харьяалах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас байгуулсан сонгуулийн нэгдсэн хороо эрхлэн явуулна.

**14 дүгээр зүйл.** Захирагчийг сонгогдсонд тооцож бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх

1. Хот, тосгоны захирагчийн сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхийн санал авсан нэр дэвшигчийг тухайн хот, тосгоны захирагчаар сонгогдсонд тооцно.

2. Хэрэв нэр дэвшигчдийн хэн нь ч олонхийн санал аваагүй бол сонгуульд оролцсон нийт сонгогчийн хамгийн олон санал авсан хоёр хүнийг дахин санал хураалтад оруулна. Дахин санал хураалтад оролцсон нийт сонгогчийн олонхийн санал авсан нэр дэвшигчийг тухайн хот, тосгоны захирагчаар сонгогдсонд тооцно.

3. Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасны дагуу сонгогдсон улсын зэрэглэлтэй хотын захирагчийн бүрэн эрхийг Ерөнхий сайд, аймгийн зэрэглэлтэй хотын захирагчийн бүрэн эрхийг аймгийн Засаг дарга, тосгоны захирагчийн бүрэн эрхийг сумын Засаг дарга тус тус хүлээн зөвшөөрнө.

4. Хот, тосгоны захирагчийн сонгууль явуулах, огцруулах тухай журмыг Улсын Их Хурал тогтооно.



**15 дугаар зүйл.** Хот, тосгоны захирагчийг чөлөөлөх, огируулах

1. Хот, тосгоны захирагчийг өөрийн нь хүсэлт, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар ажлаас нь чөлөөлнө.

2. Захирагчийг огируулах саналыг сонгуулийн эрх бүхий оршин суугчдын 30-аас доошгүй хуви нь бичгээр гаргасан, түүнчлэн Ерөнхий сайд, аймаг, сумын Засаг дарга үндэслэл бүхий санал гаргасан бол захирагчийг огируулах эсэх асуудлаар оршин суугчдын санал хураалтыг явуулна.

3. Гэмт хэрэг үйлдсэн болохыг тогтоосон шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон, мөн түүнчлэн тухайн оршин суугчдын олонхи нь огируулахыг дэмжвэл захирагчийг огируулна.

4. Энэ зүйлийн 1, 3 дахь хэсэгт заасныг үндэслэн хот, тосгоны захирагчийг чөлөөлөх, огируулах тухай шийдвэрийг Ерөнхий сайд болон харьяалах аймаг, сумын Засаг дарга тус тус гаргана.

**16 дугаар зүйл.** Хот, тосгоны захирагч ажлаа тайлагнах

Хот, тосгоны захирагч нь ажлаа тухайн хот, тосгоны оршин суугчдад жилд 2 удаа тайлагнаж, үйл ажиллагааныхаа талаар Ерөнхий сайд болон харьяалах аймаг, сумын Засаг даргад тус тус мэдээлж байна.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Хот, тосгоны захирагчийн бүрэн эрх

**17 дугаар зүйл.** Төлөөлөлт, төсөв, санхүү бүртгэлийн талдархи хот, тосгоны захирагчийн бүрэн эрх

1. Хот, тосгоны нийгэм, эдийн засгийн хөгжлийн үндсэн чиглэл, хөтөлбөрийг бодовчруулан харьяалах аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, түйцэтгэлийг зохион байгуулна.

2. Хот, тосгоны ерөнхий төлөөлөгчөө хууль тогтоомжид заасан журмаар батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

3. Улсын төвлөрсөн ба орон нутгийн төсвөөс хот, тосгонд хувьчилсан төслийг хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулна.

4. Хот, тосгоны нийгэм, эдийн засгийн хөгжилд шаардлагатай санхүү, эдийн засаг, хөдөлмөр эрхлэлт, нөөцийн болон газар ашиглаалтын зэрэг мэдээ, тайлаанг тухайн хот, тосгоны холбогдох байгууллага, албан тушаалтнаар гаргуулна.

**18 дугаар зүйл.** Хот, тосгоны өөрийн мэдлийн өмчийг захиран зарцуулах, аж ахуйн нэгж, байгууллагатай харилцах талаархи хот, тосгоны захирагчийн бүрэн эрх

1. Хот, тосгоны өөрийн мэдлийн өмчийг хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулж, тэдгээрийг шинээр бий болгох, түрээслэх асуудлыг шийдвэрлэнэ.

2. Хот, тосгоны оршин суугчдын ашиг сонирхолд нийцүүлэн хот, тосгоны өөрийн мэдлийн өмчийг хувьчлах асуудлыг боловсруулж хууль тогтоомжид зэвсэг журмаар шийдвэрлүүлнэ.

3. Хот, тосгоны оршин суугчдын хэрэгцээг хангахад чиглэгдсэн үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгоход тус дэмжлэг үзүүлнэ.

4. Хот, тосгоны өөрийн мэдлийн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг чиглүүлж, удирдлагыг нь томилж, чөлөөлнө.

5. Хот, тосгоны нийгэм, эдийн засгийн хөгжлийн асуудлыг шийдвэрлэх талаар аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллаж, хүсний болон өргөн хэрэгцээний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх талаар гэрээ байгуулна.

**19 дүгээр зүйл.** Газар ашиглах болон байгаль хамгаалах талаархи хот, тосгоны захирагчийн бүрэн эрх

1. Хот, тосгоны эдэлбэр газрын ашиглалтыг төлөвлөнө.

2. Хот, тосгоны дэвсгэр нутагт явуулж буй газар зохион байгуулалтын төлөвлөгөөний талаар санал гаргана.

3. Хот, тосгоны усны нөөцийг тогтоосон журмын дагуу ашиглуулна.

4. Хот, тосгоны ариун цэвэр, эрүүл ахуй-халдваргүйжүүлэлтийн арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулна.

5. Хот, тосгоны экологийн байдлын талаар оршин суугчдад мэдээлэл хийнэ.

6. Хот, тосгоны хүрээлэн байгаа орчин, ногоон бүсийг хамгаалах, сэргээх арга хэмжээ боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

7. Хот, тосгоны экологи, эрүүл ахуйн хэм хэмжээ зөрчсөн барилда байгууламжийг барьж аниглахыг зогсоох асуудлыг эрх бүхий байгууллагад оруулна.

**20 дугаар зүйл.** Орон сууц нийтийн аж ахуй ба худалдаа үйлчилгээний талаархи хот, тосгоны захирагчийн бүрэн эрх

1. Хот, тосгоны өөрийн мэдлийн орон сууцыг тогтоосон журмын дагуу хуваарилна.

2. Хот, тосгоны тохижилтын ажилд аж ахуйн нэгж, байгууллагыг гэрээний үндсэн дээр, түүнчлэн оршин суугчдыг зохион байгуулж оролцуулна.

3. Хот, тосгоны өөрийн мэдлийн аж ахуй, худалдаа, үйлчилгээний байгууллагын ажиллах цагийн хуваарийг тогтооно.

4. Худалдаа, үйлчилгээний газарт эрүүл ахуйн шаардлагыг хангуулна.

5. Худалдаа, нармаг болон үйлчилгээний бусад арга хэмжээг зохион байгуулна.

**21 дүгээр зүйл.** Оршин суугчдын нийгмийн хамгаалалт болон ахуйн соёлын хэрэгцээг хангах талаархи хот, тосгоны захирагчийн бүрэн эрх

1. Оршин суугчдын хөдөлмөр эрхлэлтийн түвшинг дээшлүүлэх хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.

2. Боловсрол, соёл, эрүүлийг хамгаалах, нийгэм хангамж, биений тамир-спортын байгууллагаас үйл ажиллагаагаа явуулахад дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

3. Оршин суугчдын эрүүл мэндийг хамгаалах, өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэдгээрийн амьдрах орчин, үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг хангах арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлнэ.

4. Оршин суугчдаас нийгмийн хамгаалалт, дэмжлэг үзүүлбэл зохих амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур амьдралтай хэсэгт санхүүгийн болон эд материалын тусламж үзүүлэх санг зарим ажил, үйлчилгээнээс өрсөн орлогоос бүрдүүлнэ.

5. Түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалж, тэдгээрийн ашиглалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулна.

**22 дугаар зүйл.** Барилда, тээвэр, холбооны талаархи хот, тосгоны захирагчийн бүрэн эрх

1. Хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөний дагуу нарийвчилсан төлөвлөгөө, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

2. Хот, тосгоны өөрийн мэдлийн хөрөнгөөс буюу хувь оролцон байгуулж буй эдийн засаг, үйлдвэрлэлийн дэд бүтцийн объектыг барих, засварлахад захирагчийн үүрэг гүйцэтгэнэ.

3. Хот, тосгоны дэвсгэр нутагт барилга байгууламж барих зөвшөөрөл олгох талаар санал гарган, ашиглалтад орж байгаа орон сууц, иргэний зориулалттай барилга байгууламжийг хүлээн авна.

4. Хот, тосгоны өөрийн мэдлийн өмчийн тээврийн байгууллагыг удирдаж, нийтийн тээврийн үйлчилгээний чиглэл, цагийн хуваарийг батлан, түүнчлэн оршин суугчдад үйлчилж байгаа тээврийн бусад байгууллагын үйл ажиллагаанд болон төмөр зам, нисэх буудалд зорчигчдын үйлчилгээг зохион байгуулж байгаад хяналт тавина.

5. Хот, тосгоны өөрийн мэдлийн радио, телевизийн байгууллагын үйл ажиллагааг чиглүүлднэ.

### 23 дугаар зүйл. Хот, тосгоны захирагчийн бусад бүрэн эрх

1. Нийгмийн дэг журмыг хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх талаар хууль хяналтын байгууллагатай харилцан ажиллаж, тэдгээрт туслалцаа үзүүлднэ.

2. Оршин суугчдын санал, өргөдөл, гомдол, тэдний ашиг сонирхлыг хамгаалахтай холбогдсон асуудлыг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол хянан шийдвэрлэнэ.

3. Хот, тосгоны шагналыг бий болгоно.

4. Хот, тосгоны бэлгэдлийг батална.

5. Бусад улсын хот, тосгонтой холбоо тогтооно.

6. Захирагчийн ажлын албаны ажилтныг томилж, чөлөөлнө.

7. Урамшил, туслэмж, энэрэнгүй үйлсийн болон хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдсэн өөрийн мэдлийн мөнгөн савтай бэйж болно.

### 24 дүгээр зүйл. Хот, тосгоны зөвлөлийн эрх хэмжээ

Хот, тосгоны зөвлөл дараахь эрх хэмжээтэй байна:

1) энэ хуулийн 17 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг, 19 дүгээр зүйлийн 1, 2, 7 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 1, 3, 4, 5 дахь хэсэгт заасан асуудлыг хэлэлцэх;

2) захирагчийн ажлын албаны үйл ажиллагааг хянан хэлэлцэх;

3) аж ахуйн нэгж, байгууллагаас хот, тосгоны хөгжилд оруулсан буюу оруулах хувь нэмрийн талаар хэлэлцэх.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

**Хот, тосгоны захирагчийн бүрэн эрхийн баталгаа**

25 дугаар зүйл. Хот, тосгоны захирагчийн шийдвэр

1. Хот, тосгоны захирагч бүрэн эрхийнхээ хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн захирамж гаргана.

2. Хот, тосгоны захирагчийн захирамж хууль тогтоомжид нийцээгүй бол өөрөө өөрчилж, хүчингүй болгож эсхүл Ерөнхий сайд болон харьяалах аймаг, сумын Засаг дарга тус тус хүчингүй болгоно.

26 дугаар зүйл. Хот, тосгоны захирагчийн шийдвэрийг биелүүлэх

Хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан хот, тосгоны захирагчийн шийдвэрийг тухайн хот, тосгоны дэвсгэр нутаг дахь аж ахуйн нэгж, байгууллага, оршин суугч биелүүлэх үүрэгтэй.

27 дугаар зүйл. Хот, тосгоны захирагчийн зардал

Хот, тосгоны захирагчийн зардлыг тухайн хот, тосгонд хуваарилсан төсвөөс санхүүжүүлнэ.

28 дугаар зүйл. Хот, тосгоны захирагчийн тамга, тэмдэг

Хот, тосгоны захирагч нь тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудаастай байна.

## ТАВДУГААР БҮЛЭГ

**Хот, тосгоны оршин суугч**

29 дүгээр зүйл. Оршин суугч

Энэ хуульд заасан суурин газарт байнгын хаягийн бүртгэлтэй иргэнийг хот, тосгоны оршин суугч гэнэ.

30 дугаар зүйл. Оршин суугчийн эрх, үүрэг

1. Хот, тосгоны оршин суугч нь дараахь эрх эдэлнэ:

1) хөдөлмөрийн захад бүртгэлтэй оршин суугч нь тухайн хот, тосгоны аж ахуйд ажлын байр хуваарилахад тэргүүн ээлжинд хангагдах;

2) сонгуулийн эрх бүхий оршин суугч нь тухайн хот, тосгоны удирдлагыг сонгох, түүнд сонгогдох;

3) хотын хүндэт иргэний болзол хангах;

4) аливаа асуудлаар шууд буюу харьяалах Засаг даргаар уламжлан захирагчид санал, хүсэлтээ гаргах.

2. Хот, тосгоны оршин суугч нь дараахь үүрэг хүлээнэ:

1) хот, тосгоны хэмжээнд зохиогдож буй тохижилт, үйлчилгээ, цэвэрлэгээнд оролцох;

2) хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөний дагуу өөрийн орон байрыг тохижуулах, орчноо цэвэр үзэмжтэй байлгах;

3) хот, тосгоны эдэлбэр газарт байгаа өөрийн эзэмшлийн газрыг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлж үр ашигтай ашиглах.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ

**Хот, тосгоны удирдлагаас төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагатай харилцах**

**31 дүгээр зүйл. Төрийн захиргааны төв байгууллагатай харилцах**

1. Улсын зэрэглэлтэй хотын захирагч нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллаж, үйл ажиллагаагаа уяадуулан зохицуулна. Шаардлагатай гэж үзвэл асуудлыг Засгийн газарт тавьж шийдвэрлүүнэ.

2. Улсын зэрэглэлтэй хотын захирагч нь салбар болон салбар хоорондын бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор төрийн захиргааны төв байгууллагатай хамтарсан шийдвэр гаргаж болно.

3. Бүрэн эрхийнхээ хүрээнд хууль тогтоомжид шийдүүлэн гаргасан хот, тосгоны захирагчийн шийдвэрийг хэрэгжүүлэхэд төрийн захиргааны төв байгууллага саад учруулаж үл болно.

**32 дугаар зүйл. Нутгийн захиргааны байгууллагатай харилцах**

1. Хот, тосгоны захирагч нь өөрийн шийдвэрийн талаар харьяалах засаг захиргааны нэгжийн иргэдийн Нийтийн

болон Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж болно.

2. Хот, тосгоны захирагч нь харьяалах засаг захиргааны иргэдийн Нийтийн болон Төлөөлөгчдийн Хурлаас гаргасан шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй.

3. Захирагчийн шийдвэрт харьяалах засаг захиргааны нэгжийн Засаг дарга үүрэг хүлээхээр тусгагдан тохиолдолд уг шийдвэрийг хэрэгжүүлэх боломжгүй гэж үзвэл Засаг дарга үдгэлзүүлж болно.

4. Хот, тосгоны захирагч нь эдийн засаг, аж ахуйн асуудлаар Засаг даргатай харилцан ажиллах бөгөөд хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол улсын зэрэглэлтэй хотын захирагч, аймгийн Засаг даргын хооронд үүссэн маргааныг Ерөнхий сайд, аймгийн зэрэглэлтэй хот, тосгоны захирагч, сум, багийн Засаг даргын хооронд үүссэн маргааныг харьяалах дээд шатны Засаг дарга тус тус шийдвэрлэнэ.

## ДОЛДУГААР БҮЛЭГ

### Бусад зүйл

33 дугаар зүйл. Хотын бэлгэдэл, нэрэмжит цол, бусад шагнал

1. Хот нь өөрийн түүх, уламжлал, байгалийн онцлог зэргийг нлэрхийлсэн бэлгэдэлтэй байж болох бөгөөд бэлгэдлийн хэв загварыг тудайн хотын оршин суугчдын саналыг харгалзан хотын захирагч батална.

2. Хотын хүндэт иргэний болзол хангасан болон хотыг хөгжүүлэх ажилд онцгой хувь нэмэр оруулсан хүмүүст хүндэт иргэн цол олгох, байгуулаага, хамт олон, хүмүүсийг хүндэт гэмдэг, нэрэмжит болон бусад шагналаар шагнах, хүндэт дэвтэрт бичин алдаршуулах асуудлыг захирагч шийдвэрлэнэ.

34 дүгээр зүйл. Хотын тэмдэг, мэдээлэл

Хот сонин, сэтгүүл, радио, телевизтэй байж болно.

35 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1994 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ

1993 оны 12 дугаар  
сарын 24-ний өдөр

Улаанбаатар  
хот

ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсад орох, гарах, дамжин өнгөрөх, оршин суух журам, тэдний эрх, үүргийг тогтоож, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж, олон улсын гэрээ

1. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрднө.

3 дугаар зүйл. Гадаадын иргэн

Гадаад улсын харьяат мөн болохыг гэрчилсэн хууль ёсны нотолгоотой хүнийг гадаадын иргэн гэнэ.

4 дүгээр зүйл. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай Монгол Улсын хуулийн хамаарах этгээд

Энэ хуулийн заалт нь Монгол Улсад зорчигч, тус улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөгч, түр буюу удаан хугацаагаар оршин суугч, цагаач гадаадын иргэн, харьяалаагүй хүн (цаашид энэ хуульд «гадаадын иргэн» гэх)-д хамаарна.



**5 дугаар зүйл.** Дипломат төлөөлөгчийн болон консулын газрын ажилтнуудын дипломат эрх ямба, дархан эрх

Энэ зүйлийн эдэлт нь хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээгээр тогтоосон гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгуулалтын суурин төлөөлөгчийн гварын ажилтнуудын дипломат эрх ямба, дархан эрхийг хөнддөггүй.

**6 дугаар зүйл.** Улс төрийн иргэд

1. Мөс гол Улсад эрхэмлэн дээдэлж үзэх санааны төлөө хавчигдан мөнгөтгөсөн гадаадын иргэнд тус улсад оршин суух эрх олгож төрийн илээлд авч болно.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу гадаадын иргэнд тус улсад оршин суух эрх олгох тусай асуудлыг Монгол Улсын Ерөнхийлөгч шийдвэрлэнэ.

**7 дугаар зүйл.** Гадаадын иргэдийн асуудал эрхлэх байгууллага

1. Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэдийн эрх зүйн байдал, цагаачлалтай холбогдсон асуудлыг төрийн захиргааны төв байгууллагууд тус тусын чиг үүргийн дагуу эрхэлнэ.

2. Монгол Улсад гадаадын иргэдийн талар баримтлах төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд хяналт тавьж, төрийн захиргааны төв байгууллагуудын гадаадын иргэдийн эрх зүйн байдал, цагаачлалтай холбогдсон үйл ажиллагааг уялдуулан чиглүүлэх чиг үүргийг Гадаадын иргэдийн асуудал эрхлэх зөвлөл (шавинд «Зөвлөл» гэх) хэрэгжүүлнэ.

3. Зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Зөвлөлийн нарийн бичгийн дарга орон тооны байна. Энэ Зөвлөлийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гашүүн тэргүүнэ.

4. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Засгийн газар тогтоож, дүрмийг батална.

## ХОЕРДУГААР БҮЛЭГ

### Гадаадын иргэний эрх зүйн байдал

**8 дугаар зүйл.** Гадаадын иргэний эрх, үүргийн үндсэн зарчим

1. Монгол Улсын нутаг дэвсгэрт хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.

2. Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн тус улсын хууль тогтоомжоор өөрт нь олгогдсон эрх, эрх чөлөөг Монгол Улсын иргэний нэгэн адил эдэлж, үүрэг хүлээнэ.

3. Монгол Улс энэ хууль, хууль тогтоомжийн бусад акт болон Монгол Улсын олон улсын гэрээгээр гадаадын иргэний эрх, үүргийг тодорхойлохдоо уг иргэнийг харьяалсан улстай энэ талаар харилцан адил байх зарчим баримтална.

4. Гадаадын иргэн Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын гэрээгээр тодорхойлогдсон эрх, эрх чөлөөг Монгол Улсын эрх ашиг, тус улсын иргэний болон бусад хүний эрх, хууль ёсны ашиг сонирхолд харшаар эдэлж болохгүй.

**9 дүгээр зүйл.** Монгол Улсын Үндсэн хуулийг хүндэтгэх, хууль тогтоомжийг сахин биелүүлэх

1. Гадаадын иргэн энэ хууль болон хууль тогтоомжийн бусад актаар тогтоосон үүрэг хүлээнэ.

2. Гадаадын иргэн нь Монгол Улсын Үндсэн хуулийг хүндэтгэж, хууль тогтоомжийг сахин биелүүлж, Монголын ард түмний уламжлал, ёс заншилыг хүндэтгэх үүрэгтэй.

3. Гадаадын иргэн хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол татвар төлөх үүрэгтэй.

**10 дугаар зүйл.** Гадаадын иргэний эрх, үүргийн онцлог

1. Гадаадын иргэн Монгол Улсын төрийн болон засаг захиргааны нэгж, хот, тосгоны өөрөө удирдах байгууллаагсад сонгох, сонгогдох эрх эдлэхгүй, ард нийтийн санал асуулгад оролцохгүй.

2. Гадаадын иргэн Монгол Улсын төрийн жинхэнэ албан хаагчаар ажиллахгүй.

3. Гадаадын иргэн Монгол Улсын эзэсэгт хүчин, бусад цэрэгт алба хаах үүрэг хүлээхгүй.

4. Гадаадын иргэн Монгол Улсын нутаг дэвсгэрт улс төрийн нам болон улс төрийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага байгуулах буюу түүнд элсэн орж болохгүй.

5. Монгол Улсын үндэсний эв нэгдлийг эсрэг сурталчилгаа явуулахыг хориглоно.

6. Гадаадын иргэн улсын оиц нухал объект гэж хуулиар тогтоогдсон газарт Засгийн газрын зөвшөөрснөөр ажиллаж болно.

7. Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд хүний салшгүй эрхээс бусад асуудлаар гадаадын иргэний эрх, эрх чөлөөнд хуулиар хязгаарлал тогтоож болно.

### 11 дүгээр зүйл. Хөдөлмөр эрхлэх

1. Монгол Улсад удаан хугацаагаар оршин суугч, цагаач гадаадын иргэн нь хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон түүний эрх олгосон байгууллагын зөвшөөрөлтэйгээр энэ хууль болон хууль тогтоомжийн бусад актаар хориглосноос бусад ажил, албан тушаалд болон гадаадын байгууллагад ажиллаж болно.

2. Монгол Улсад удаан хугацаагаар оршин суугч, цагаач гадаадын иргэн нь тус улсын хууль тогтоомжийн дагуу аж ахуйн нэгж байгуулж, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах бол хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөл авна.

3. Хөдөлмөрийн гэрээгээр ирсэн гадаадын иргэн гэрээний хугацаа дууссан буюу хугацаанаас өмнө гэрээгээ цуцалсан тохиолдолд өөр аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй гэрээ байгуулж болохгүй.

4. Түр хугацаагаар оршин суугч гадаадын иргэн ирсэн зорилгоосоо гадуур орлого олох зорилгоор хувиараа буюу аж ахуйн нэгж, байгууллагад ажил хөдөлмөр эрхлэх, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж үл болно.

5. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн аль ч хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлийн үндсэн дээр гадаад улс, олон нийтийн байгууллагаас мэргэжилтэн, ажиллах хүч авах тухай хөдөлмөрийн гэрээ байгуулна.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Монгол Улсын виз, Монгол Улсад орох, гарах, дамжин өнгөрөх

#### 12 дугаар зүйл. Монгол Улсын виз

1. Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаадын иргэн Монгол Улсад орох, гарах, дамжин өнгөрөхдөө Монгол Улсын визийг авсан байна.

2. Визийг хүчин төгөлдөр гадаад паспорт буюу түүнийг орлох хууль ёсны баримт бичигтэй гадаадын иргэнд олгоно. Визийг хавсралт хуудсан дээр олгож болно.

3. Виз нь дипломат, албан, эргийн гэсэн зэрэгтэй байна.

4. Виз нь орох, орох-гарах, гарах, гарах-орох, дамжин өнгөрөх зорилгоотой нэг, хоёр, олон удаагийн гэсэн ялгаатай байна.

5. Визийн загварыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд батална.

#### 13 дугаар зүйл. Виз олгох байгууллага

1. Визийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, гадаад улсад суугаа Монгол Улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар олгоно.

2. Монгол Улсын хилийн цэргийн шалган нэвтрүүлэх алба дамжин өнгөрөх визгүй ирсэн гадаадын иргэнд дамжин өнгөрөх виз олгож болно.

#### 14 дүгээр зүйл. Виз олгох байгууллагын эрх, үүрэг

1. Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага виз олгох дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

1) Монгол Улсын визийн нэгдсэн бүртгэлийг хөтлөх;

2) виз олгох үйл ажиллагааг нэгтгэл зохицуулах;

3) олгогдсон визийн үндэслэлийг хянах;

4) виз олгохоос татгалзах, түүний дугаанааг богиносгох, сунгах, олгосон визийг хүчингүй болгох;

5) зайлшгүй шаардлагатай тохиролдолд олон улсын нэгдсэн буудлаар виз олгох.

2. Цагдаагийн төв байгууллага виз олгох дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

1) Монгол Улсад байгаа цагаач, харьяалаагүй хүнд олгосон визийн бүртгэлийг хөтлөх;

2) хууль тогтоомжид харшлах үндэслэл байвал виз олгохөөс татгалзах.

3. Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосноор Монгол Улсын өргөмжлөлт консул Монгол Улсад орох виз олгож болно.

15 дугаар зүйл. Виз олгох үндэслэл

1. Монгол Улсад албан хэргээр ирэх гадаадын иргэнд виз олгоход дараахь зүйлийг үндэслэнэ:

1) Монгол Улсын төрийн болон засаг захиргааны нэгж, хөт, тосгоны өөрөө удирдах байгууллага, Улсын Их Хуралд суудал бүхий намын урилга, хүсэлт;

2) тус улсад суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газар, Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагын суурин төлөөлөгчийн газарт ажиллах гадаадын иргэд, тэдгээрийн гэр бүлийн гишүүний талаар тэдгээрийг харьяалах улс, олон улсын байгууллагын гаргасан албан ёсны хүсэлт, бусад тохноолдолд Монгол Улсын олон улсын гэрээний заалт.

2. Монгол Улсад хувийн хэргээр ирэх гадаадын иргэнд виз олгоход дараахь зүйлийг үндэслэнэ:

1) цагдаагийн төв, орон нутгийн байгууллагаас гэрчлэн нотолсон урилга;

2) аялан жуулчлах, эмчлүүж сувилауулах, ёслолд оролцох, гачигдал зэргээр ирэх тохноолдол холбогдох гэрээ, гэрчлэн нотлогдсон урилга, Монгол Улсын хүлээн авах байгууллагын зөвшөөрөл;

3) ажил хөдөлмөр эрхлэх, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах, эрдэм шинжилгээний ажил хийх болон суралцах зорилгоор гадаад орноос ирэх хүмүүсийн хувьд тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тодорхойлолт;

4) энэ зүйлийн 3-д зааснаас бусад ажлаар гадаад орноос ирэх хүний хувьд аж ахуйн нэгж, байгууллагын шийдвэр;

5) Монгол Улсад амьдрах, буцаж явах хөрөнгийн эх үүсвэрийн талаар тухайн хүнээс гаргасан буюу Монгол Улсад хүлээн авах байгууллага, иргэнээс бичгээр гаргасан баталгаа.

3. Монгол Улсад цагаачлан ирэх гадаадын иргэнд виз олгоход дараахь зүйлийг үндэслэнэ:

1) цагаачлах үндэслэл бүхий хүсэлт, гэрчлэн нотолсон биений байцаалт;

2) Монгол Улсын эрх бүхий байгууллагын зөвшөөрөл;

3) хөл хорих өвчингүй болохыг нотолсон олон улсын эрүүд мэндийн гэрчилгээ;

4) Монгол Улсад амьдрах хөрөнгийн эх үүсвэрийн талаар тухайн хүнээс бичгээр гаргасан баталгаа.

**16 дугаар зүйл.** Визийн хугацаа

Монгол Улсад зорчигч гадаадын иргэнд орох-гарах визийг 30 хүртэл хоногийн хугацаагаар олгоно. Визийн хугацааг нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно.

**17 дугаар зүйл.** Монгол Улсад орох

Хүчин төгөлдөр гадаад паспорт буюу түүнийг орлох хууль ёсны баримт бичигтэй, Монгол Улсын эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөлтэй гадаадын иргэн хууль тогтоомжид заасан журмын дагуу Монгол Улсын хилийн боомтоор нэвтрэнэ.

**18 дугаар зүйл.** Монгол Улсаар дамжин өнгөрөх

1. Хүчин төгөлдөр гадаад паспорт буюу түүнийг орлох хууль ёсны баримт бичигтэй гадаадын иргэн Монгол Улсын эрх бүхий байгууллагын зөвшөөрөл авч Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрнө;

2. Олон улсын нислэгээр дамжин өнгөрөх гадаадын иргэн дамжин өнгөрөх виз авах шаардлагагүй. Харин автомашин, тээврийн бусад хэрэгслээр буюу явганаар зорчих хүмүүс зохих хугацааны дамжин өнгөрөх виз авна.

**19 дүгээр зүйл.** Гадаадын иргэнийг Монгол Улсад орохыг үл зөвшөөрөх

Гадаадын иргэнийг дараахь үндэслэл байвал Монгол Улсад орохыг үл зөвшөөрнө:

1) насанд хүрээгүй буюу эрх зүйн чадамжгүй хүн хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй бол;

2) Монгол Улсад байхдаа ял шийтгүүлж, ял шийтгэлтэйд тооцох хугацаа нь дуусаагүй бол;

3) тааламжгүй этгээд гэгдсэний улмаас Монгол Улсаас албадан гаргагдсан бол;

4) Монгол Улсын үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахад хэршлэж байвал.

**20 дугаар зүйл.** Монгол Улсаас гарах, гарахыг түдгэлзүүлэх

1. Гадаадын иргэн Монгол Улсад байхыг зөвшөөрсөн хугацаанд багтаж тус улсаас гарч явах үүрэгтэй.

2. Гадаадын иргэнийг дараахь үндэслэл байвал дор дурдсан хугацаанд Монгол Улсад гарахыг түдгэлзүүлнэ:

1) гэмт хэргэгт сэжигтэн, иллагадгаар татагдсан бол уг хэргийг шийдвэрлэх хүртэл;

2) эрүүгийн ял шийтгүүлсэн бол ял эдэлж дуусах, буюу ялаас чөлөөлөх, эсхүл тухайн хүнийг Монгол Улсын олон улсын гэрээний дагуу харьяалах улсад нь шилжүүлэх хүртэл;

3) бусад хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хохироож байгаа тухай нөгөө этгээд буюу байгууллагын өргөдөл, гомдол байгаа бөгөөд эрх бүхий байгууллага үүнийг үндэслэлтэй гэж үзсэн бол уг асуудлыг шийдвэрлэх хүртэл;

4) Монгол Улсын үндэсний болон хувь амын аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах ашиг сонирхолд харшвалж байвал.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### Монгол Улсад зорчих, оршин суух

**21 дүгээр зүйл.** Гадаадын хувь Монгол Улсад оршин суух

Хүчин төгөлдөр гадаад паспорт буюу түүнийг орлох хууль ёсны баримт бичигтэй гадаадын иргэн Монгол Улсын эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөл, энэ хуульд заасан үндэслэлийн дагуу Монгол Улсад зорчиж, оршин сууж болно.

**22 дугаар зүйл.** Монгол Улсад зорчигч, түр буюу удаан хугацаагаар оршин суугч, цагаач гадаадын иргэн

1. Энэ хуульд заасан үндэслэлээр Монгол Улсад 30 хоног хүртэл хугацаагаар албан болон хувийн хэргээр ирсэн гадаадын иргэнийг зорчигч гэнэ.

2. Монгол Улсад 183 хүртэл хоногийн хугацаагаар байгаа гадаадын иргэнийг түр оршин суугч гэнэ.

3. Монгол Улсад 5 жил хүртэл хугацаагаар оршин суугаа гадаадын иргэнийг удаан хугацаагаар оршин суугч гэнэ.

4. Хувийн хэргээр Монгол Улсад байгаа амьдран суугаа гадаадын иргэнийг цагаач гэнэ.

**23 дугаар зүйл.** Оршин суух хугацаа сунгах

Цагаачаас бусад гадаадын иргэнээс Монгол Улсад оршин суух хугацааг сунгуулахаар гаргасан хүсэлтийг уг асуудлыг

эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянан үзэж шийдвэрлэнэ.

**24 дүгээр зүйл.** Монгол Улсад байх цагаач гадаадын иргэдийн тоо, бүтэц

1. Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суух цагаач гадаадын иргэдийн тоо нь Монгол Улсын харьяат хүн амын 1 хувь, үүний дотор нэг улсын иргэн 0,33 хувиас хэтрэхгүй байна.

2. Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тус улсад оруулж болох цагаач гадаадын иргэдийн тоо, бүтэц болон засаг захиргааны нэгжид оршин суух цагаачийн тоог улс орноор нь жил бүр тогтоож байна.

**25 дугаар зүйл.** Цагаач гадаадын иргэнд оршин суух зөвшөөрөл олгох, түүнийг сунгах, хүчингүй болгох

1. Монгол Улсад цагаачлан ирэх гадаадын иргэний хүсэлт, шаардагдах бусад баримт бичгийг Зөвлөл хянан үзээд улс орны дотоод нөхцөл байдал, эдийн засгийн чадамж, хүлээн авах байгууллагын захналга, цагаачлан ирэх хүний боловсрол, мэргэжил, хэлний мэдлэг, аялаас, чадварыг харгалзан 5 жилийн хугацаагаар Монгол Улсад оршин суух зөвшөөрөл олгоно.

2. Цагаач гадаадын иргэний орших суух хугацааг сунгах асуудлыг нэг улсын иргэдээс байвал зохих цагаачийн тоонд багтан Зөвлөл шийдвэрлэнэ.

3. Монгол Улсад цагаачлан ирсэн гадаадын иргэн жилд 50 хоногоос дээш хугацаагаар тус улсын нутаг дэвсгэрт байгаагүй бол цагаачлан суух зөвшөөрлийг Зөвлөл буцаан авч энэ тухай түүнд мэдэгдэнэ. Тухайн хүн уг мэдэгдэлийг хүлээн авсан өдрөөс 7 хоногийн дотор шүүхэд гомдлоо гаргах эрхтэй.

4. Цагаач гадаадын иргэн хууль тогтоомж ноцтой зөрчсөн бол Зөвлөл түүнд олгосон Монгол Улсад оршин суух зөвшөөрлийг хүчингүй болгоно.

**26 дугаар зүйл.** Гадаадын иргэнийг бүртгэх

1. Монгол Улсад төрийн болон засаг захиргааны нэгж, хот, тосгоны өөрөө удирдах байгууллагын урилгаар ирснээс бусад гадаадын иргэнийг урьж ирүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, хүн ирсэн өдрөөс хойш 10 хоногийн дотор багтаан цагдаагийн байгууллагад бүртгүүлнэ.



2. Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагын суурин төлөөлөгчийн газар, мөн хэвлэл, мэдээллийн төлөөлөгчийн газару ажлаар байгаа гадаадын иргэн, тэдгээрийн гэр бүлийн гишүүнийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад Монгол Улсад ирсэн өдрөөс хойш 10 хоногийн дотор бүртгүүлнэ.

3. Монгол Улсад ирсэн Засгийн газрын бус болон олон улсын хүмүүнлэгийн байгууллагын ажилтан хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор бүртгүүлнэ.

4. Хуульд өөрөөр заагаагүй бол тус улсын нутаг дэвсгэрт оршин суугаа цагаач гадаадын иргэн өөр засаг захиргааны нэгжид шилжин суурьших бол оршин сууж байсан нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын бүртгэлээ хасуулж, очсон газрын цагдаагийн байгууллагад 7 хоногийн дотор бүртгүүлж, оршин суух үнэмлэхдээ тэмдэглэл хийлгэнэ.

5. Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа цагаач гадаадын ирсэн ам бүлийнхээ байдал, хөдөлмөр эрхлэлтийн талаарх хөдөлгөөн, өөрчлөлтийг 7 хоногийн дотор оршин суугаа газрын цагдаагийн байгууллагад мэдэгднэ.

6. Монгол Улсад улсын хугацаагаар оршин суугч цагаач гадаадын иргэн хувийн хэргээр бусад засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэрт 7 хоногоос дээш хугацаагаар зорчих тохиролдолд очсон газрынхаа цагдаагийн байгууллагад бүртгүүлнэ.

7. Цагдаагийн төв байгууллага нь Монгол Улсад орж ирсэн, гарч явсан болон дамжин өнгөрсөн гадаадын иргэдийн мэдээг улсын хил хамгаалалтын байгууллагаас тогтсон маягаар сэр бүр аяч гадаадын иргэдийн хөдөлгөөнд хяналт тавьж, мөн тус улсын нутаг дэвсгэрт гэмт хэргэ үйлдсэн, ял шийтгүүлсэн, ял шийтгэлтэйд тооцогдож байгаа, Монгол Улсаас албадан гаргагдсан болон олон улсын эрх бүхий байгууллагаас аливаа улс оронд орохыг хориглосон, эрэн сурвалжаагдаж байгаа гадаадын иргэний тухай мэдээг Монгол Улсын холбогдох байгууллагад өгч байна.

**27 дугаар зүйл. Харьгалаагүй хүн гадаадад зорчих**

1. Монгол Улсад оршин суугаа харьгалаагүй хүн гадаадад зорчих болно.

2. Гадаадад зорчих харьгалаагүй хүнд цагдаагийн төв байгууллагаас баримт бичиг олгоно.

3. Хуульд өөрөөр заагаагүй бол гадаадад зорчих харьяалалгүй хүнд виз олгоход Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн холбогдох заалтыг баримтална.

**28 дугаар зүйл.** Монгол Улсад оршин суугаа цагаач харьяалалгүй хүнд олгох баримт бичиг

1. Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа цагаач, харьяалалгүй хүнд цагдаагийн төв байгууллагаас засаг захиргааны аль нэгжийн оршин суугч болохыг заасан «Монгол Улсад оршин суух үнэмлэх» олгоно.

2. Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа цагаач, харьяалалгүй хүн гадаадад зорчихдоо оршин суух үнэмлэхээ бүртгэл бүхий цагдаагийн байгууллагад хадгалуулж, бүрмөсөн явах тохиолдолд хураалгана.

3. Гадаадад зорчих харьяалалгүй хүнд олгох баримт бичгийн загварыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

## ТАВДУГААР БҮЛЭГ

### Бусад асуудал

**29 дүгээр зүйл.** Гадаадын иргэнийг урих, ажиллуулах талаар аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хүлээх үүрэг

1. Монгол Улсад төдөрхөй хугацаагаар гадаадын иргэнийг урьсан, ажиллуулах зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэд нь түүнийг хууль тогтоомжийн дагуу зохиох байгууллагад нь бүртгүүлэх, орон байраар хангах үүрэгтэй.

2. Монгол Улсад байгаа гадаадын байгууллага, аж ахуйн нэгж нь гаднаас мэргэжлийн хүн, ажиллах хүч хууль тогтоомжийн дагуу урьж ажиллуулбал Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллагын нэгэн адил үүрэг хүлээнэ.

**30 дугаар зүйл.** Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах

1. Гадаадын иргэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй байвал Монгол Улсаас дараахь үндэслэлээр албадан гаргана:

1) Монгол Улсад хүчин төгөлдөр бүс болон хуурамч бичиг баримтаар орж ирсэн буюу оршин суух хугацаа нь дууссан боловч тус улсаас гарч явахад зайлсхийсэн;

2) Монгол Улсад оршин суух зөвшөөрлийг хүчингүй болгосон буюу буцаан авсан бодолч тухай Гадаадын иргэн тус улсаас гарч явахад зайлсхийсэн;

3) Монгол Улсаас албадан гаргах тухай Зөрчлийн шийдвэрийг цагдаагийн байгууллагад гүйцэтгэнэ, Гадаадын иргэн үе шийдвэрт заасан хугацаанд Монгол Улсаас гарах үүрэгтэй.

4) Албадан гаргахад гарсан зөрчилт гэм буруутай этгээд хариуцна.

5) Албадан гаргах нь улс хооронд ямар ч шалжүүлэх асуудал үл хамарна.

**31 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчилдөд хүлээлгэх хариуцлага**

Гадаадын иргэний эрх зүйн байдалын тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн болон захиргааны хариуцлагын тухай хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

**32 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

Энэ хуулийг 1994 оны 2 дугаар сарын 4-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1993 оны 12 дугаар  
саямын 24-ний өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ИРГЭН ГАДААДАД ХУВИЙН ХЭРГЭЭР ЗОРЧИХ, ЦАГААЧЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах, эх орондоо буцаж ирэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл.** Монгол Улсын иргэн хувийн хэргээр гадаадад зорчих, цагаачлах тухай хууль тогтоомж, олон улсын гэрээ

1. Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

**3 дугаар зүйл.** Гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах

1. Төрийн болон засаг захиргааны нэгж, хот, тосгоны өөрөө удирдах байгууллага, Улсын Их Хуралд суудаал бүхий нам, төрийн гүйцэтгэх байгууллагын тусгай чиг үүрэг буюу дэд салбарын тодорхой чиг үүргийг Засгийн газрын шийдвэр, түүнчлэн гэрээний үндсэн дээр эрхлэн гүйцэтгэж байгаа байгууллагын ажлаар явахгаас бусдыг гадаадад хувийн хэргээр зорчих гэнэ.

2. Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр байнга амьдран суухаар Монгол Улсаас гарч явахыг цагаачлах гэнэ.

**4 дүгээр зүйл.** Гадаадад хувийн хэргээр зорчих,  
цагаачлах эрх

1. Монгол Улсын иргэн хувийн хэргээр гадаадад зорчих, цагаачлах эрхтэй.

**2.** Гадаадад цагаачилсан Монгол Улсын иргэн хэдийд ч эх орондоо буцаж ирэх эрхтэй.

**5 дугаар зүйл.** Гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх

1. Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах эрдийг дараахь үндэслэлээр дор дурдсан хугацаагаар түдгэлзүүнэ:

1) гэмт хэрэгт сэжигтэн, яллагдагчаар татагдсан бол уг хэргийг шийдвэрлэх хүртэл;

2) эрүүгийн ял шийтгүүлдсэн бол уг ялыг эдэлж дуусах буюу ялаас чөлөөлөх хүртэл;

3) хуулиар тогтоосон төрийн нууцыг мэдэж байгаа болон түүнийг шууд харууцаж байгаа албан тушаалтан цагаачлах хүсэлт гаргахан бол уг ажлаас халагдсан, чөлөөлөгдсөн өдрөөс хойш 3 жилийн дотор;

4) гадаадад зорчих, цагаачлах нь бусад хүний эрх, эрл чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хохироож байгаа тухай нөгөө этгээд буюу байгууллагын өргөдөл, гомдол байгаа бөгөөд эрх бүхий байгууллага түүнийг үндэслэлтэй гэж үзсэн бол уг асуудлыг шийдвэрлэх хүртэл.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад үндэслэлээр Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах эрхийг хязгаарлахыг хориглоно.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх үндэслэл байгаа эсэхэд цагдаагийн байгууллага хиналт тавина.

4. Гадаад улсад байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул, гоц халдварт өвчин, оиц болон дайны байдал бий болсны улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд аюул учирч болзошгүй нөхцөл буй болсон бол Засгийн газар уг улсад зорчих, цагаачлах иргэдэд энэ тухай урьдчилан мэдээлэх арга хэмжээ авах үүрэгтэй.

**6 дугаар зүйл.** Гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлахад зөвшөөрөл олгох

1. Гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах иргэн тухайн улсын виз авахыг өөрөө харууцна.

2. Энэгүй зорчих гэрээ нөхцөл бүхий улсад Монгол Улсын иргэн өөрийн хүсэлтээр чөлөөтэй зорчиж болно.

3. Гадаадад хувийн хэргээр зорчих иргэн цагдаагийн байгууллагад үндэсний гадаад паспорт авах хүсэлт бичгээр гаргаж, дараахь баримт бичгийн аль нэгийг бүрдүүлж өгнө:

1) аж ахуйн нэгж, байгууллагын ажлаар ивэж байгаа бол ажилтнаа гадаадад ивуулах тухай уг байгууллага, аж ахуйн нэгжийн шийдвэр;

2) эмчлүүлж сувицуулах буюу зуннарав хөдөлмөр эрхлээд, суралнахаар ивэж байгаа бол эрх бүхий байгууллагын, мн-гадлагаа, шийдвэр;

3) өвчтөн хүргэх, эдгэх, аач ирэх, ёслолд оролцох, хувийн гачагдлаар явах бол гадаадын халбогдох байгууллага, хү-мүүсээс ирүүлсэн дуудлага, гэрчлэл нотлогдсон урилга;

4) гадаадын байгууллага, аж ахуйн нэгжийн албан ёсны урилга буюу хувь хүний гэрчлэл нотлогдсон урилга.

4. Энэ зүйлийн 3 дахь хэсгийн заалт нь олон удаа зорчих зөвшөөрөл бүхий үндэсний гаднад паспорттай иргэдэд үл хамаарна.

5. Гадаадад цагаачлах иргэн цагдаагийн байгууллагад дараахь баримт бичиг гаргаж өгнө:

1) цагаачлах болон үндэсний гаднад паспорт авах хүсэлт;

2) ажиллаж байсан аж ахуйн нэгж, байгууллагатай хө-дөлмөрийн гэрээгээ дуусганаар болгосон болон өмчийн ор ан-длагатгүй болохыг нотолсон тодорхойлолт;

3) хөдөлмөр эрхлээгүй бол оршин суугаа нутгийн захир-гааны байгууллагын тодорхойлолт.

6. Гадаадад цагаачлах иргэн шаардлагатай тохиолдолд энэ зүйлийн 5 дахь хэсэгт зааснаас гадна дараахь баримт бичгийн аль нэгийг цагдаагийн байгууллагад бүрдүүлж өгнө:

1) гадаадын байгууллагатай хөдөлмөр эрхлэлтийн асууд-даар байгуулсан гэрээ;

2) тэр бүл нь гадаадын иргэн бол энэ тухай баримт бич-гийн нотархитаар гэрчлэсэн хуулбар;

3) гадаадад байгаа оршин суудаг төрөл саднаас нь ирүүл-сэн гэрчлэл нотлогдсон урилга.

7. Цагдаагийн байгууллага гадаадад хувийн хэргээр зор-чих иргэний үндэсний гадаадад паспорт авах хүсэлтийг 10 до-ног, цагаачлах хүсэлтийг 30 хоногийн дотор тус тус шийдвэр-лэнэ. Шаардлагатай тохиолдолд цагаачлах хүсэлтийг шийд-вэрлэх хугацааг 30 хүртэл хоногоор суугаж болно.

8. Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үн-дэслэлээр иргэний гадаадад хувийн хэргээр зорчих, цагаач-лах эрхийг гүдгэлзүүлсэн тохиолдолд цагдаагийн байгуу-лага үндэслэл бүхий хариуг бичгээр өгнө.

9. Иргэд гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлахтай халбогдсон томдлоо шүүхэд гаргана.

10. Цагдаагийн төв байгууллага гадаадад цагаачлан гаргах Монгол Улсын иргэдийн тоо бүртгэлийг нэгтгэн зөвөлнө.

7 дүгээр зүйл. Насанд хүрээгүй буюу эрх зүйн чадамжгүй хүү гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах.

1. Насанд хүрээгүй буюу эрх зүйн чадамжгүй хүү гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлахад зөвхөн эцэг, эх буюу хууль ёсны асран хамгаалагч, хэргэдээн дэмжигчийн хамт дала.

2. Монгол Улсын 16—18 насны иргэн эцэг, эх, асран хамгаалагчийн хамт цагаачлах тохиолдолд түүний зөвшөөрлийг нь бичгээр авна.

8 дугаар зүйл. Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлахад олгох баримт бичиг, үндэсний гадаад паспорт

1. Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах бол түүнд Монгол Улсын үндэсний гадаад паспорт олгоно.

2. Насанд хүрээгүй хүү гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах бол түүнд үндэсний гадаад паспорт олгох буюу эцэг, эх, асран хамгаалагчийн үндэсний гадаад паспортад хавсралт хийж өгнө.

3. Монгол Улсын үндэсний гадаад паспорт нь Монгол Улсын төрийн оюу мөн.

4. Монгол Улсын иргэн гадаадад байхдаа үндэсний гадаад паспортгаа үрэгдүүлсэн, гэмтээсэн тохиолдолд түүнд үндэсний гадаад паспорт буюу Монгол Улсад буцах үнэмлэхийг Монгол Улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар олгоно.

5. Монгол Улсын үндэсний гадаад паспортыг тус улсад цагдаагийн байгууллага, гадаадад дипломат төлөөлөгчийн болон консулын газар олгоно.

6. Монгол Улсын үндэсний гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журмыг Засгийн газар тогтооно.

7. Монгол Улсын үндэсний гадаад паспорт, Монгол Улсад буцах үнэмлэхийн загварыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

9 дүгээр зүйл. Гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах Монгол Улсын иргэний эрх, үүрэг

1. Монгол Улсын иргэн гадаадад байхдаа төрийнхээ ивээлд байж, зөрчигдсөн хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хуулийн дагуу хамгаалуулах эрхтэй.

2. Монгол Улсын иргэн гадаадад цагаачлахдаа өөрт нь болон хамт цагаачлах гэр бүлийн гишүүдэд оногдох өмч, гаднаад валютыг хууль тогтоомжийн дагуу авч гарах эрхтэй.

3. Гадаадад удаан хугацаагаар (6 сараас дээш) болон цагаачлан суугаа иргэдийн өмчлөлийн болон өвлөх эрхтэй холбогдсон асуудлыг Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

4. Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлахтай холбогдсон аливаа зардлыг өөрөө хариуцах үүрэгтэй.

5. Гадаадад удаан хугацаагаар болон цагаачлан суугаа Монгол Улсын иргэн тус улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газарт хэргийн бүртгэл хийлгэж байх үүрэгтэй.

Гадаадад хувийн хэргээр түр хугацаагаар зорчиж яваа Монгол Улсын иргэн өөрөө хүсвэл дипломат төлөөлөгчийн болон консулын газарт бүртгэл хийлгэж болно.

#### 10 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчдэд хүлээлгэх хариуцлага

1. Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн болон захиргааны хариуцлагын тухай хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

2. Үндэсний гадаад паспортаа үрэгдүүлсэн, гэмтээсэн Монгол Улсын иргэнд консулын албан тушаалтан Захиргааны хариуцлагын тухай хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

#### 11 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1994 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.



МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ

1993 оны 12 дугаар  
сарын 24-ний өдөр

Улаанбаатар  
хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1987 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн «БНМАУ-д байгаа гадаадын иргэдийн эрх, үүргийн тухай БНМАУ-ын хууль»-ийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Эмэ хуулийг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай Монгол Улсын хууль хүчин төгөлдөр болсон нэрнээс эхлэн дагаж мөрдсүгэй.

Монгол Улсын Их Хуралын  
дарга

Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1993 оны 12 дугаар  
сарын 24-ний өдөр

Улаанбаатар  
201

### ДАРХЛАЛЫН ӨЛДМӨЛ ХОМСДОЛ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь хүн амыг дархлалын өлдмөл хомсдол өвчнөөс сэргийлэх, түүнтэй тэмцэх талаар төрийн, эрүүт мэндийн болон холбогдох бусад байгууллага, эмч, эмнэлгийн ажилтан, иргэд, уг өвчний халдаар лисан буюу өвчлөсөн хүний эрх, үүргийг тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Дархлалын өлдмөл хомсдол өвчнөөс сэргийлэх тухай хууль тогтоомж, олон улсын гэрээ

1. Дархлалын өлдмөл хомсдол өвчнөөс сэргийлэх тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бүтэд ахлаас бүрдэнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Засгийн Газрын эрх, үүрэг

1. Засгийн газар хүн амыг дархлалын өлдмөл хомсдол өвчнөөс сэргийлэх, түүнтэй тэмцэх талаар дараахь эрх, үүргийг хэрэгжүүлэнэ:

1) дархлалын өлдмөл хомсдол өвчнөөс сэргийлэх тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулж, хяналт тавих;

2) хүн амыг дархлалын өлдмөл хомсдол өвчнөөс сэргийлэх, түүнтэй тэмцэх талаар төрийн Соёлого боловсруулж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

3) дархлалын олдмол хомсдол өвчний халдвар авсан буюу өвчилсөн хүмүүс эрхэлж болохгүй ажил, үйлчилгээг тогтоох.

2 Засгийн газар энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2-г заасан эрх, үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан байгууллага, салбар хөврөндийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий үндэсний хороог байгуулан ажилдуулах болно.

4 дүгээр зүйл. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх, үүрэг

Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүн амыг дархлалын олдмол хомсдол өвчнөөс сэргийлэх, түүнтэй тэмцэх талаар дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

1) хүн амыг дархлалын олдмол хомсдол өвчнөөс сэргийлэх, түүнтэй тэмцэх асуудлыг боловсруулах, энэ талаар гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

2) дархлалын олдмол хомсдол өвчний халдвар, өвчлөлтэй холбогдсон албан ёсны мэдээллийг хариуцах;

3) дархлалын олдмол хомсдол өвчний халдварт өртөмтгий болон халдвар тараах боломж бүхий бүлгийг тогтоох;

4) энэ зүйлийн 3 дахь заалтад заасан бүлэгт хамаарагдах хүмүүс дархлалын олдмол хомсдол өвчний халдвар илрүүдэх үзлэг, шинжилгээ хийлгэж байх хугацаа, халдвар авсан буюу өвчилсөн хүмүүст хяналт тавих, эмнэлгийн тусламж үзүүлэх тухай журам тогтоож, биелэлтийг нь хангах;

5) дархлалын олдмол хомсдол өвчний халдварыг бусдад дамжуулахгүй байх талаар уг өвчний халдвар авсан буюу өвчилсөн нь тогтоогдсон хүн болон түүний хууль ёсны асран хамгаалагчдад өгөх албан зааварчилгыг батлах.

5 дугаар зүйл. Эрүүл мэндийн байгууллагын эрх, үүрэг

Эрүүл мэндийн байгууллага хүн амыг дархлалын олдмол хомсдол өвчнөөс сэргийлэх, түүнтэй тэмцэх талаар дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

1) хүн амын дунд дархлалын олдмол хомсдол өвчний халдвар илрүүдэх, магадлах, уг өвчнөөр өвчилсөн хүмүүсийг эмчлэх арга хэмжээ авах;

2) хариуцсан нутаг дэвсгэртээ оршин суугаа дархлалын олдмол хомсдол өвчний халдвар авсан буюу өвчилсөн нь тогтоогдсон хүн уг өвчний халдварыг бусдад халдаахгүй байх талаар мэргэжлийн хяналт тавих, түүнд болон түүний хууль ёсны асран хамгаалагчдад албан зааварчилга өгөх ажлыг зохион байгуулах;

3) зүү, тариур болон эмнэлгийн бусад багаж хэрэгслээр

дархлаалын олдмол хомсдол өвчний халдвар тархахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх;

4) дархлаалын олдмол хомсдол өвчний халдвар нэрүүлэх шинжилгээ хийж баталгаажуулахгүй цусны бүтээгдэхүүн, донорын эд эрхтэнийг эмчилгээ, сэргийлэлтийн зориулалтаар хэрэглэхгүй байх.

**6 дугаар зүйл.** Засаг даргын эрх, үүрэг

Бүх шатны Засаг дарга тус тусын эрх хэмжээний хүрээнд хүн амыг дархлаалын олдмол хомсдол өвчнөөс сэргийлэх, түүнтэй тэмцэх талаар дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

1) дархлаалын олдмол хомсдол өвчнөөс сэргийлэх тухай хууль тогтоомжийн биелэлтийг өөрийн харьяалах нутаг дэвсгэрт зохион байгуулж, хяналт тавих;

2) энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 3-т заасан бүлэгт хамаарагдах хүмүүсийг дархлаалын олдмол хомсдол өвчний халдвар нэрүүлэх үзлэг, шинжилгээнд оруулах ажлыг зохион байгуулах.

**7 дугаар зүйл.** Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эрх, үүрэг

Бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал өөрийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хүн амыг дархлаалын олдмол хомсдол өвчнөөс сэргийлэх, түүнтэй тэмцэх, энэ талаарх сурталчилгааны ажилд иргэд, олон нийтийн болон бусад байгууллагуыг оролдуулах, уг өвчнөөс сэргийлэх, түүнтэй тэмцэх эдийн засаг, нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авна.

**8 дугаар зүйл.** Хэвлэл, мэдээлэл, Засгийн газрын бус байгууллагын үүрэг

Хэвлэл, мэдээлэл, шашины, олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгжүүд нь дархлаалын олдмол хомсдол өвчнөөс сэргийлэх, түүнтэй тэмцэх талаар хүн амын дунд зохиох сургалт, сурталчилгааны ажилд оролцох үүрэгтэй.

**9 дүгээр зүйл.** Иргэний үүрэг

1. Монгол Улсын иргэн дархлаалын олдмол хомсдол өвчнөөс сэргийлэх, түүнтэй тэмцэх талаар дараахь үүрэг хүлээнэ:

1) дархлаалын олдмол хомсдол өвчний халдвар болон өвчнийг нэрүүлэх, магадлах эмнэлгийн үзлэг, шинжилгээ хийлгэх тухай Засаг дарга, эрүүл мэндийн байгууллагын албан ёсны шаардлагыг биелүүлэх;

2) энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 3-т заасан бүлэгт хамаарагдах хүмүүс тогтоосон хугацаанд эмнэлгийн үзлэг, шинжилгээнд орох;

3) дархлалын олдмол хомсдол өвчний халдвараас сэргийлэх, түүнтэй тэмцэх талаар төрийн, эрүүл мэндийн болон холбогдох бусад байгууллагад зохих байгуулж буй арга хэмжээнд оролцох;

4) дархлалын олдмол хомсдол өвчний халдвар авсан буюу өвчилсөн хүмүүсийн хууль ёсны эрх, амьт сонирхлыг зөрчихгүй байх;

5) дархлалын олдмол хомсдолын өвчний талаар үнэн зөв, бодит мэдээлэл өгж авах, дархлалын олдмол хомсдол өвчний халдвараас урьдчилан сэргийлэх аргад суралцах.

2. Энэ зүйлний заалт тус улсын нутаг дэвсгэрт оршин суугаа болон дамжин өнгөрөгч гадаадын иргэд, харьяалалгүй хүмүүст нэгэн адил хамаарна.

10 дугаар зүйл. Эмч, эмнэлгийн ажлагчны үүрэг.

Эмч, эмнэлгийн ажлагчтан хүн амыг дархлалын олдмол хомсдол өвчнөөс сэргийлэх, түүнтэй тэмцэх талаар дараахь үүрэг хүлээнэ:

1) эмч дархлалын олдмол хомсдол өвчин, түүний халдварыг илрүүлсэн, оношилсон тухайгаа харьяалах эрүүл мэндийн байгууллагад зохих журмын дагуу заавал мэдээлэх;

2) дархлалын олдмол хомсдол өвчний халдвар авсан буюу өвчилсөн нь тогтоогдсон хүн биеэ хэрхэн эмч авах, уг өвчний халдварыг бусдад тараахгүй байх талаар түүнд болон түүний хууль ёсны асран хамгаалагчид албан зааварчилгаа өгөх;

3) дархлалын олдмол хомсдол өвчний халдвар авсан буюу өвчилсөн нь тогтоогдсон хүнд энэ өвчин эдгэршгүй гэсэн үндэслэлээр эмнэлгийн зайлшгүй тусламж үзүүлэхээс татгалзаахгүй байх.

11 дүгээр зүйл. Дархлалын олдмол хомсдол өвчний халдвар авсан буюу өвчилсөн хүний үүрэг

Дархлалын олдмол хомсдол өвчний халдвар авсан буюу өвчилсөн хүн дараахь үүрэг хүлээнэ:

1) дархлалын олдмол хомсдол өвчний халдвар авсан буюу өвчилсөн нөхцөл, шалтгааны талаар эрүүл мэндийн байгууллагад үнэн зөв мэдээлэл өгөх;

2) эрүүл мэндийн байгууллагын шаардлагын дагуу эмнэлгийн үйлэг, шинжилгээ хийлгэх;

3) эмнэлгийн тусламж авах бүрдээ дархлалын олдмол хомсдол өвчний халдвартай буюу өвчтэй тухайгаа эрүүл мэндийн байгууллагад заавал мэдэгдэх;

- 4) цус, бусад эд, эрхтэний донор байхаас татгалзах;
- 5) халдварыг бусдад тараахгүй байх, тарааж болох аливаа үйлдэл, харилцаанаас татгалзах;
- 6) эрүүд мэндийн байгууллага, эмч, эмнэлгийн ажилтнаас өгсөн албан зааварчиагыг чанд сахин биелүүлэх;
- 7) дархлалын олдмол хөмсдол өвчний халдвар авсан буюу өвчилсөн тухайгаа Монгол Улсад орж ирэхдээ улсын хилийн эрүүд ахуй, халдвар судлалын хяналтын байгууллагад мэдэгдэх.

**12 дугаар зүйл.** Дархлалын олдмол хөмсдол өвчнөөс сэргийлэх, түүнтэй тэмцэх албадлагын эргэ хэмжээ

1. Дархлалын олдмол хөмсдол өвчин, түүний халдварыг илрүүлэх эмнэлгийн үзлэг, шинжилгээнд орвол зохих хүн элсэн хугацаанд үзлэг, шинжилгээнд орохоос санаатайгаар зайлсхийсөн байвал түүнийг Засаг даргын захирамжаар албадан ирүүлнэ.

2. Дархлалын олдмол хөмсдол өвчний халдвар авсан буюу өвчилсөн хүн өөртөө хяналт тавих чадваргүйгээс энэ хуульд заасан үүргээ биелүүлж чадахгүй болсон тохиолдолд түүнийг албадан тусгаарлаж эмчилнэ.

3. Дархлалын олдмол хөмсдол өвчний халдвар авсан буюу өвчилсөн нь тогтоогдсон хүн жирэмсэн болсон тохиолдолд эмнэлгийн байгууллагын заалтаар жирэмслэлтийг таслан зогсооно.

4. Дархлалын олдмол хөмсдол өвчний халдваргүй нь баталгаажлаагүй цус, цусны бүтээгдэхүүн, эд, эрхтэнг улсын хилээр оруулах, худалдахыг хориглоно.

5. Дархлалын олдмол хөмсдол өвчний халдвар авсан буюу өвчилсөн нь тогтоогдсон гдаадын иргэн, харьяалаагүй хүн Монгол Улсын эрүүд мэндийн байгууллагын хууль ёсны шаардлагыг биелүүлэхээс зайлсхийвэл тэднийг хууль тогтоомжид заасны дагуу тус улсын албадан гаргана.

**13 дугаар зүйл.** Дархлалын олдмол хөмсдол өвчний халдвартай холбогдуулан хүний эрхийг хамгаалах

1. Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрхшгүй эрх болон бусад эрхийг хуульд өөрөөр заагаагүй бол дархлалын олдмол хөмсдол өвчтэй буюу түүний халдвар авсан гэсэн үндэслэлээр хязгаарлахыг хориглоно.

2. Иргэд дархлалын олдмол хомсдол өвчин, түүний халдварыг илрүүлэх үзлэг, шинжилгээ, халдвар судлалын хяналт хийж байгаа хүнээс уг үзлэг, шинжилгээ, хяналтыг хийх эрхтэй болохыг нь нотлох албан ёсны баримт бичгийг шаардах эрхтэй.

3. Иргэд дархлалын олдмол хомсдол өвчин, түүний халдварыг илрүүлэх үзлэг, шинжилгээнд сайн дураараа орж болно.

4. Байгууллага, албан тушаалтан, иргэн албан ажлын шугамаар болон бусад байдлаар өөрт илэрхий болсон дархлалын олдмол хомсдолын халдвар авсан буюу өвчилсөн хүмүүсийн уг өвчний халдвар авсан шалтгаан нөхцөл, өвчний ишний талаарх хувийн нууцыг нийтэд залруулахыг хориглоно.

#### 14 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх харуцлага

Дархлалын олдмол хомсдол өвчнөөс сэргийлэх тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн харуцлага хүлээлгэхээргүй Сол тухайн шатны Засаг дарга гэм буруутай этгээдэд дор дурдсан захиргааны харуцлага хүлээлгэнэ:

1) энэ хуулийн 5 дугаар зүйлийн 3, 10 дугаар зүйлийн 3 дэх заалт, 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн бол 1000—5000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна;

2) 10 дугаар зүйлийн 1, 2 дэх заалтад заасан үүргийг биелүүлдээгүй бол 5000—10000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна;

3) 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2, 11 дүгээр зүйлийг зөрчсөн бол 10000—20000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна;

4) 5 дугаар зүйлийн 4 дэх заалт, 12 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг зөрчсөн бол 15000—25000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

#### 15 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1994 оны 3 дугаар сарын 4-ний өдрөөс эхлэн эргэж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЫН  
ТОГТООЛ

1993 оны 12 дугаар  
сарын 27-ны өдөр

Дугаар 99

Улаанбаатар  
хот

МОНГОЛ УЛСЫН ИРГЭН ХУВИЙН ХЭРГЭЭР  
ГАДААДАД ЗОРЧИХ, ЦАГААЧЛАХ ТУХАЙ БОЛОН  
ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН  
ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ  
ТУХАЙ

Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, ил-  
гаачлах тухай болон Гадаадын иргэний эрх зүйн байдлын  
тухай Монгол Улсын хууль батлагдсантай холбогдуулан Мон-  
гол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн га-  
зарт даалгасугай:

1) Сайд нарын Зөвлөл, Засгийн газрын гаргасан тогтоол,  
нийдвэрийг 1994 оны 2 дугаар сарын 1-ний дотор багтаан  
хэргээр хуульд нийцүүлэх арга хэмжээ авах;

2) эдгээр хуульд заасан дүрэм, журам, зааврыг 1994 оны  
эхний хагаст багтаан боловсруулж мөрдүүлэх;

3) Монгол Улсын хүч ам зүйн бодлогын талаар төрөөс  
баримтлах бодлогыг 1994 оны эхний хагаст багтаан боловс-  
руулж Улсын Их Хуралд өргөн барих;

4) Монгол Улсын харьяатын тухай хуулийн төслийг 1994  
онд багтаан Улсын Их Хуралд өргөн барих.

2. БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүдэгчдийн 1987 оны  
4 дүгээр сарын 16-ны өдрийн 60 дугаар зарлигийг эдгээр  
хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн хүчингүй болсонд  
тооцсугай.



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ

1993 оны 12 дугаар  
сарын 27-ны өдөр

Дугаар 100

Улаанбаатар  
хот

ДАРХЛАЛЫН ОЛДМОЛ ХОМСДОЛ ӨВЧНӨӨС  
СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ БАТЛАГДСАНТАЙ  
ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ  
ТУХАЙ

Дархлалын олдмол хомсдол өвчнөөс сэргийлэх тухай хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Дарнахь арга хэмжээг хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасугай;

1) Засгийн газраас тогтоохоор хуульд заасан жагсаалт, зааварчилга, холбогдох бусад баримт бичгийг 1994 оны 3 дугаар сарын 1-ний дотор батлаж мөрдүүлэх;

2) дархлалын олдмол хомсдол өвчний халдвартай буюу өвчтэй хүн, халдварт материалтай байнга харьцаж ажиллах үүрэг бүхий эрүүл мэндийн байгууллагуудыг материаллаг баа, боловсон хүчинээр бэхжүүлэх арга хэмжээ авах.

2. «Дархлал хомсдох хамшинж өвчнөөс сэргийлэх арга хэмжээний тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1989 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 103 дугаар зарлигийг Дархлалын олдмол хомсдол өвчнөөс сэргийлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

Арга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛЫН  
ТОГТООЛ

1993 оны 12 дугаар

сарын 28-ны өдөр

Дугаар 101

Улаанбаатар

ХОТ

ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНИЙ ТУХАЙ МОНГОЛ  
УЛСЫН ХУУЛЬ БАТЛАГДСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН  
АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Олон улсын гэрээний тухай Монгол Улсын хууль батлагдсантай холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасугай:

1) Сэйд нарын зөвлөл, Засгийн газрын тогтоол, шийдвэрийг 1994 оны эхний улиралд багтаан Олон улсын гэрээний тухай Монгол Улсын хуульд нийцүүлэх;

2) яам, тусгай газар, тэдгээрийн харьяа байгууллагууд болон аймаг, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас бусад улсын ижил төрлийн байгууллагууд болон хувь хүүх, хуулийн этгээдтэй гэрээ байгуулах журмыг 1994 оны эхний улиралд багтаан боловсруулж мөрдүүлэх.

2. «Гадаад улсын бн олон улсын байгууллага албан тушаалтантай харилцах журмыг батлах тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1971 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 50 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцугай.

Дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАМЫН  
ТОГТООЛ

1994 оны 1 дүгээр

Дугаар 1

Улаанбаатар

сарны 3-ны өдөр

хот

МОНГОЛБАНКНЫ 1994 ОНЫ ОРЛОГО;  
ЗАРЛАГЫН ТӨСВИЙГ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монголбанкны 1994 оны орлогыг 3,310,0 сая төгрөг, зарлагыг 3,040,0 сая төгрөгөөр тус тус баталсугай.

2. Монголбанкны зохлон байгуулалтын бүтэц, зардлыг төслийн хэмнэлттэй байх талаас нь судлан үзэж, 1993 оны үйл ажиллагааны тайлан тэнцлийн хамт Улсын Их Хурлын 1994 оны хаврын чуулганд танилцуулахыг Монголбанк (Д. Мөлөмжами)-д даалгасугай.

Дээрх

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛЫН  
ТОГТООЛ

1994 оны 1 дүгээр  
сарын 3-ны өдөр

Дугаар 2

Улаанбаатар  
хот

«1 ТӨГРӨГ», «10 ТӨГРӨГ», «20 ТӨГРӨГ»,  
«10 МӨНГӨ», «20 МӨНГӨ», «50 МӨНГӨ»-НИЙ  
ДЭВСГЭРТНИЙГ ХУУЛЬ ЕСНЫ ТӨЛБӨРИЙН  
ХЭРЭГСЭЛД ТООЦОХ, ГҮЙЛГЭЭНД  
ГАРГАХЫГ ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь.

1. «Мөнгөн тэмдэгийн хэрэгсэлтийг батлах тухай» Улсын Бага Хурлын 1992 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 32 дугаар тогтоолын дагуу хэвлэгдсэн «1 төгрөг», «10 төгрөг», «20 төгрөг», «10 мөнгө», «20 мөнгө», «50 мөнгө»-ний дэвсгэртний Монгол Улсын хууль ёсны төлбөрийн хэрэгсэлд тооцугай.

2. Гүйцэтгэгч байх бэлэн мөнгөний хэрэгсэлт харгалзан Монгол Улсын Банкны хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн «1 төгрөг», «10 төгрөг», «20 төгрөг», «10 мөнгө», «20 мөнгө», «50 мөнгө»-ний дэвсгэртнийг гүйцэтгэгчид гаргахыг Монголбанк (Д. Моголжамц)-д зөвшөөрсүгэй.

Дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ

1994 оны 1 дүгээр  
сарын 4-ний өдөр

Дугаар 3

Улаанбаатар  
хот

ТӨСӨЛ БУЦЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн «Хот, хороодын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын тухай», «Хот, хороодод засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж байгуулах тухай» тогтоолын төслийн хэлэлцүүлгийн явцад Монгол Улсын Үндсэн хуулийн тавин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Үндсэн хуулийн Хэлсрэлт хуулийн дөрөндүгээр зүйлийн 2 дахь хэсэгт засаг шаардлагыг хангуулах талаар гишүүдээс гаргасан зөрчлийн саналыг хэрэглээн Улсын Их Хурлын тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 7-гийн «В»-г үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

«Хот, хороодын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын тухай», «Хот, хороодод засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж байгуулах тухай» тогтоолын төслийг дахин боловсруулахаар Засгийн газарт буцаахтай.

Дарга

Н. БАГЛАНДИ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛЫН  
ТОГТООЛ

1994 оны 1 дүгээр  
сарын 4-ний өдөр

Дугаар 4

Улаанбаатар  
ХОТ

ХОТ, ТОСГОНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ  
ХУУЛНИГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА  
ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль батлагдсантай хөлбөгдүүлэн дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасугай:

1) хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд нийцүүлэх;

2) хотын зэрэглэл, хот, тосгоны захирагчийн ажлын албаны бүтэц, орон тооны хязгаарыг нэгбүрчлэн буюу нэг маягаар тогтоох асуудлыг 1994 оны 3 дугаар сард багтаан шийдвэрлэх;

3) хот, тосгоны захирагчийн сонгуулийг 1994 оны эхний хэсэгт багтаан явуулах.

2. Хот, тосгоны захирагчийн сонгууль явуулах, огцруулах тухай журмыг боловсруулж 1994 оны 3 дугаар сарын 1-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Хурал, захиргааны болон Хууль зүйн байнгын хороонд даалгасугай.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хурал, захиргааны байнгын хороонд даалгасугай.

Дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛЫН  
ТОГТООЛ

1994 оны 1 дүгээр

сарын 6-ны өдөр

Дугаар 5

Улаанбаатар

хот

ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТИЙН  
ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн зарим зүйл, заалт нь Үндсэн хуулийг зөрчиж байна гэж үзсэн иргэн Ө. Сэргэлэн, Н. Баасанжав нарын өргөдөөд дурдсан гомдлыг хангах үндэслэлгүй гэсэн Үндсэн хуулийн цэцийн 1993 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 04 дүгээр дүгнэлтийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тогтоох хэсгийн 1 дүгээр заалтыг хүлээн зөвшөөрсүгэй.

Дэргэ

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ

1993 оны 12 дугаар

сарын 30-ны өдөр

Дугаар 128

Улаанбаатар

ХОТ

ИШЦОГИЙН ОЧИРБАЛД ДИПЛОМАТ  
ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Монгол Улсын Гадаад харилцааны яамны Европ, Америкийн газрын ерөнхий захирал Ишцогийн Очирбалд Монгол Улсыг НҮБ-д гишүүнээр элсэх үеэс эхлэн түүний үйл ажиллагаанд үр бүтээлтэй оролцох, НҮБ-ын төрөлжсөн байгууллага, хөгжлийн хөтөлбөрийн шугамаар тусламж авах эхлэлийг тавих үйлэт идэвх зүтгэлтэй оролцож ирээ.

Тэрээр Их Британи ба Умард Ирландын Нэгдсэн Вант Улсад суугаа манай улсын элчин сайдаар (Дани, Нидерланд, Норвеги, Шведэд хавсран) томилогдон ажиллахдаа Британи Петролеум компанийн хөрөнгөөр газрын тос хайх асуудлыг шийдвэрлэхэд идэвхтэй оролцож, холбогдох баримт бичгүүдийг боловруулан гаргах, Азийн хиймэл дагуулыг манай орны холбоонд ашиглах, дэлхийн шуурхай шуудангийн сэлбэрийг Монголд байгуулах зэрэгт санаачилга гарган ажилласан байна.

Эдүгээ ОХУ, АНУ, Европын холбооны гол тэргүүлэгч орнуудтай туншийн харилцаа хөгжүүлэх, Монгол Улсын төр, засгийн бодлогыг хэрэгжүүлэх талаар идэвх чармайлттай ажиллаж байгаа зэрэг үр бүтээлтэй үйл ажиллагааг үнэлж, Гадаад харилцааны яамны Европ, Америкийн газрын ерөнхий захирал Ишцогийн Очирбалд «Ош бөгөөд Бүрэн эрхт элчин сайд» дипломат цол олгосугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ

1993 оны 12 дугаар  
сарын 30-ны өдөр

Дугаар 129

Улаанбаатар  
хот

ЛУВСАНДОРЖИЙН ДАВААГИЙТ ДИПЛОМАТ  
ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Монгол Улсаас АНУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Лувсандоржийн Даваагйн гаднаад харилцааны салбарт агаарынхаас Элчин сайд хүртэл дээшн 20 гаруй жил ажиллахдаа Монгол-Англи, Монгол-Америкийн харилцааг өргөжүүлэн хөгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулжээ. Монгол Улсаас Америкийн Нэгдсэн Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар томилогдож, хоёр орны тор, засгийн удирдлагын түвшинд ярил талархал үргэлжлүүлэх, хамтын ажиллагааны төлөрхөй асуудал шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх талаар идэвх сандарчигатай ажиллаж Монгол Улсын гаднаад харилцааг өргөжүүлэх үйлсэд оруулж буй хувь нэмрийг үнэлж, Монгол Улсаас АНУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Лувсандоржийн Даваагийн «Онц бөгөөд Бүрэн эрхт элчин» дипломат цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЛЭГЧИЙН  
ЗАРЛИГ**

1993 оны 12 дугаар  
сарын 30-ны өдөр

Дугаар 130

Улаанбаатар  
хот

**АГВААНДОРЖИЙН ЦОЛМОНД ДИПЛОМАТ  
ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ**

Монгол Улсаас ХБНГУ д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Агваандоржийн Цолмон гадаад харилцааны салбарт агаарын замаар Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд хүртэл дэвшил амжилтаар Монгол Улсын гадаад бодлогыг хэрэгжүүлэх үйлсэд үр бүтээлтэй хүчин зүтгэж байна.

Афганистан улсад элчин сайдаар ажиллах хугацаанд Элчин сайдын ямааг зээсэгт халдлагаас хамгаалах, ажилтан нарийнхаа аюулгүй байдлыг хангах, ЭСЯ-ны холбоог найдвартай байлгах талаар хамт олны хүчийг зөв зохион байгуулж шуурхай арга хэмжээ авч байв.

1990 онд Монгол Улсаас Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар томилогдож, хоёр орны улс төр, эдийн засгийн харилцааг бүх түвшинд идэвхжүүлэх, Монгол, Германы харилцааны тулгуур баримт бичгийг байгуулах талаар идэвх чармайлттай ажиллаж байгаа зэрэг Монгол Улсын Гадаад харилцааны бодлогыг хэрэгжүүлэх талаар идэвх зүтгэлтэй ажиллаж байгааг үнэлж Монгол Улсаас ХБНГУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Агваандоржийн Цолмонд «Онц бөгөөд Бүрэн эрхт элчин» дипломат цол олгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНШИЛЭГЧИЙН  
ЗАРЛИГ

1993 оны 12 дугаар

Дугаар 131

Улаанбаатар

сүүл 30-ны өдөр

хот

ДАШДАВААГИЙН ЧУЛУУНДОРЖИД ДИПЛОМАТ  
ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Монгол Улсын Гадаад харилцааны яамны хэргэл, мэдээллийн хэлтсийн дарга Дашдаваагийн Чулуундорж Монгол Улсын Гадаад харилцааны яаманд хэлтсийн дарга, Югослав, Энэтхэг Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд зэрэг өндөр харууллагатай амба танил, олон жил идэвх зүтгэн, үр бүтээлтэй ажилласна байна. Монгол Улсаас Япон, Энэтхэг зэрэг Азийн орнууд, Югослав улстай улс төр, соёл, худалдаа, эдийн засгийн харилцаа идэвхжүүлэн хөгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулжээ. Югослав, Энэтхэг улсад элчин сайдаар ажиллах хугацаанд Югослав улсаас эочид буудал, гинхон эдлэлийн үйлдвэр баруулах, Энэтхэг улсаас эзэлэх тэдгүүдийг хэрэгжүүлэхэд идэвх санаачлагатай оролцож, улс төрийн харилцааг өндөр түвшинд байлгах зэрэг Монгол Улсын гадаад боллогыг хэрэгжүүлэх үйлсэд оруулж буй хувь нэмрийг үнэлж Гадаад харилцааны яамны хэргэл, мэдээллийн хэлтсийн дарга Дашдаваагийн Чулуундоржид «Онц бөгөөд Бүрэн эрхт элчин» дипломат цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭГИЙН ДҮГНЭЛТ

1994 оны 1 дүгээр

Дугаар 01

Улаанбаатар

сарны 7-ны өдөр

ЖОТ

### МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬТАЙ ХӨЛБӨГДСӨН МАРГААНЫГ ХЯНАН ХЭЛЭЛЦСЭН ТУХАЙ

Үндсэн хуулийн Цэгийн хуралдааны дүгнэлтийг 1994, 1.7-ны өдөр төрийн ордны 251-р тасалгаанд үйлдэв. Цэгийн хуралдааныг Цэгийн гишүүн Г. Нямдоо даргалж гишүүдэд Л. Баасан, Н. Жанцан, (илтгэгч), С. Жанцан, Д. Чилхаажав нар оролцов. Цэгийн хуралдааны нарийн бичгийн даргаар Цэгийн нарийн бичгийн дарга Цэндээхүү маргагч талыг төлөөлж Монгол Улсын иргэн С. Зориг, А. Энхбат, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Улсын Их Хурлын гишүүн Ц. Шарандорж, Г. Ганболд нар тус тус оролцов.

Монгол Улсын иргэн С. Зориг, А. Энхбат нар Монгол Улсын Үндсэн хуулийн Цэнд хандаж гаргасан өргөдөл, түүнд холбогдуулан өгсөн тайлбартаа доорхи асуудлыг тавьж байна.

1. Монгол Улсын Шүүхийн тухай хуульд «Хуулиар шүүхэд харьяалуулсан хэрэг, маргаан» гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 14-ийн агуулгад нийцэхгүй болжээ. Учир нь хуулиар шүүхэд харьяалуулаагүй хэрэг маргаан гэж байна. Түүний талаар шүүхээс өөр ямарваа нэг байгууллага эцсийн шийдвэр гаргаж болно гэсэн логик санааг агуулж байна. Хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой аливаа асуудлыг хуулийн дагуу байгуулагдсан шударга шүүх д шийдвэрлэх ёстой гэж үзжээ.

2. Шүүгчийг шилж сонгохтой холбогдож гарсан Шүүхийн ерөнхий зөвлөлийн шийдвэр эцсийн байх тухай шүүхийн тухай хуулийн 42-р зүйлийн 2-р заалт, Шүүгчид сахилгын шийтгэл оноосон сахилгын хороо, шүүхийн ерөнхий зөвлөлийн шийдвэрийн талаар шүүгч шүүхэд гомдол гаргах эрхийг хязгаарласан заалтууд нь Үндсэн хуулийн 16-р зүйлийн 14-т

иргэн бүхэн шүүхэд гомдол гаргах, шударга шүүхээр шүүгэх эрхийг хлэсэн байна гэж үзжээ.

3. Шүүхийн ерөнхий зөвлөл нь Үндсэн хуульд злэснаар хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах зэрэг шүүхийн бие даан ажиллахтай холбоотой үүргийг бие-зүүлэх ёстой. Гэтэл шүүхийн ерөнхий зөвлөл бүх шүүгчдэд сахилгын хэрэг үүсгэх, сахилгын хэргийг хэлэлцэх, сахилгын шийтгэлийн төрөл сонгох эрхтэй болсон нь (хуулийн 49-р зүйлийн 3, 4) тухайн байгууллагын үндсэн чиг үүрэг болох шүүгчдийн эрх ашгийг хамгаалах явдлыг шийтгээ, арга хэмжээ авч айлгадаг чиг үүргээр цохсон байна гэж үзжээ.

4. Монгол улсын Шүүхийн тухай хуулийн 41-р зүйлийн заалт нь шүүгчид нэр дэвшигчдийг бүртгэхдээ шүүгчээр томлох хүний болзлыг бүртгэх үед хангасан байхаар заасан нь Үндсэн хуулийн 51-р зүйлийн 3 дахь заалтын агуулгыг зөрчиж байна. Шүүгчээр томлох хүний болзол Ерөнхийлөгч томлох үед л бүрэн хангагдсан байх ёстой гэж үзжээ.

Ийм алдаанаас болж Дээд шүүхийн шүүгчээр ажиллаж байсан Дашдоржийг нас хүрээгүй гэдгээр, Цэцэгэг ажилласан жил дутуу гэдгээр тус тус бүртгэхээс татгалзсан болохыг тэмдэглээд дээрх хүмүүсийг гэрчээр асуухыг хүсэлт болгосон байна.

Монгол Улсын иргэн Ш. Шагдарсүрэн Үндсэн хуулийн Цэцэд «Эрх чөлөө» сонинны 1993.12.30-ны дугаараар дамжуулж гомдол гаргахдаа «Шүүхийн тухай хуулийн 64-р зүйлийн 9-р заалтад Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, шүүгч гадаадад зорчих, байх хугацаандаа дипломат эрх, дархан эрх эдэлнэ» гэсэн заалт Үндсэн хуулийн 10-р зүйлийн 1, 2-ыг зөрчиж байна. Дипломат эрх, дархан эрх эдлэх асуудлыг тухайн улсын парламент зарлахгүй, олон улсын конвенцийн дагуу олгох ёстой гэжээ.

Үндсэн хуулийн Цэцэд Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Ц. Шаравдорж, Г. Ганболд нар өгсөн тайлбартаа:

Хууднаар шүүхэд харьяалуулсан хэрэг маргаан гэж байна. Тухайлбал Үндсэн хуулийн Цэцэд харьяалагдах маргааныг хэлж болно. Ийм учраас энэ заалтыг санамсаргүй авч хэрэглээгүй.

Мөн шүүхийн ерөнхий зөвлөлийн нэг үндсэн үүрэг нь Шүүгчдийг шилж сонгох надал ийм учраас энэ асуудлаараа эцсийн шийдвэр гаргаж болно. Хэрэн шүүгчдийг томлох, сахилгын арга хэмжээ авах бүхэнд шүүхэд зэргалдаад байна

ээвэл Шүүгчийг шүүх томлох, шүүгчийг шүүх шивж сонгох  
нууцдаг болно. Тэгэхээр хараат бус шүүх бүрэлдүүлэх бо-  
ломжгүй болно. Сахилагын хороо бол эдсийн шийдвэр гарга-  
даг байгууллага биш. Сахилагын хорооны шийдвэрийн талаар  
шүүхэд томлох гаргах эрхгүй гэж энэ хуулинд заагаагүй.

Шүүгчид сахилагын хариуцлага хүлээлгэж байгаа нь нэг  
галдас шүүгчдийн эрх амгуйг хамгаалж байгаа хэлбэр гэж  
үзэх үндэстэй.

Хуульчдаас шүүгчийг шилж олох ажлын эхний шатны нэг  
бол шүүгчид нэр дэвшигчдийг бүртгэхдээ Үндсэн хуулийн  
шаардлагыг хангасан эсэхийг ялгах үүрэгтэй байх нь зүйн  
хэрэг. Ерөнхийлөгчөөс шүүгчдийг томлох хугацаа нь урьдчил-  
мэдэгддэг зүйл биш.

Мөн Манай улсын Үндсэн хуульд ерөнхий шүүгч, шүүгчид  
дипломат эрх, дархан эрх эдлүүлэхийг хориглосон зүйл байх-  
гүй гэсэн зийлбарыг өгчээ.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийг Улсын Их Хурлаас  
хэвлэсэн бичлэх үед маргагч талуудаас Үндсэн хуулийн Цэ-  
нэд хандаж байгаа дээрх асуудлуудаар Үндсэн хууль зөрчсөн  
эсэх тухай маргаан үндсэндээ болоогүй байна. Харин уг  
хуулийн 2-р хэсэгшүүгчийн үед 1993.2.1-ний хуралдаан дээр  
Улсын Их Хурлын ерөнч дарга Ж. Гомбожав хэлэхдээ «Үнд-  
сэн хуулийн заалт ёсоор бол Ерөнхий зөвлөл шүүгчийн эрх  
амгуйг хамгаалах ёстой. Өөрөө шивж сонгоод дараа нь  
шийтгээд байгаа явдал бол тэрэнд нийцж байна уу? Үгүй  
явдал бол Үндсэн хуулийн шүүгчийг нийтгээд байгаа  
Үндсэн хууль зөрчсөн заалт орж байна гэж үзэж байна.  
хэмээн маргажээ».

Монгол Улсын Үндсэн хуулийн Цэнэд гадаад харилцааны  
намны Гэрээ эрхийн хэлтсийн дарга Н. Сүхбаатар өгсөн  
тодорхойлолтодоо:

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн  
2-р заалт Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, шүүгч гадаа-  
д эрх зөвлөх, байх хугацаанд дипломат эрх ямба, дархан  
эрх эдэлнэ гэсэн заалт нь Үндсэн хуультай нийцэхгүй байна.  
Энэ нь дотоодын хууль тогтоомжийг олон улсын хууль тог-  
тоомжоос дээгүүр тавьж байгаа асуудал. Өөрөөр хэлбэл  
Монгол улс тодорхой хүмүүсээ гадаадад байхад нь диплома  
эрх, дархан эрх эдлүүд гэж тулгаж байгаа хэрэг. Диплома  
паспорттай хүмүүсийг гадаад улсад хүндэтгэнэ. Харин тэ-

дипломат эрх ямба, дархан зүх эдлэх эрх зэвсгүүд нь тухайн улсын дотоод зэвсгүүд. Энэ тухай дипломат харилцааны тухай Венийн конвенц болон олон улсын хамгаалалтыг хүлээх хүмүүс түүний дотор зөвхөөрөө төлөөлөгчдийн эсрэг гэмт хэргээг урьдчилж сэргийлж болно юуу. Иэрлүүлэх тухай конвенцид тодорхой заасна. Эцгээр конвенцид Монгол Улс нэгдэн орсон юм гэжээ.

Хянавал: Монгол Улсын иргэн С. Зориг, А. Энхбат, III Шадарсүрэн нарын гомлолдоо дурдсан «Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 41 дүгээр зүйл, 42 дугаар зүйлийн 2 дэх хэсэг, 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 64 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуультай зөрчилдөг байна» гэсэн хүсэлтийг хүлээн авах үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуульд заасан шүүгчийг томлоход тавих шаардлагыг Монгол Улсын Шүүхийн тухай хуульд шүүгчид нэр дэвшигчдийг бүртгэх үед хангасан байхыг шаардсанаараа үндсэн хуулийн агуулгад нийцээгүй байна.

Шүүгчийг шилж сонгохтой холбогдож гарсан шүүхийн ерөнхий зөвлөлийн шийдвэр эрсийн байх тухай Монгол улсын шүүхийн хуулийн заалт нь нэр дэвшигч иргэнийхээ хувьд эрх нь зөрчилдсөн гэж үзвэл шүүхэд томдод гаргах эрхийг хязгаарлажээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 48-р зүйлийн 24 дэх хэсэгт шүүхийн ерөнхий зөвлөл шүүх, шүүгчийн шүүн таслах ажлалагаанд оролцохгүйгээр, таснуу хуульдаас шүүгчийг шилж олох, эрх шигийг нь хамгаалж эрэг шүүхийн бие даан ажилдах нөхцөлөөр хангахтай холбогдсон үүргийг биедүүлнэ гэж заажээ.

Гэтэл Монгол Улсын Шүүхийн тухай хуулиар Шүүхийн ерөнхий зөвлөлд сахилгын хэргэ үүсгэх (хуулийн 47-р зүйлийн 1 дэх хэсэг), сахилгын хэргийг хэлэлцэх, сахилгын шийтгэлийн төрөл сонгох (хуулийн 49-р зүйлийн 3, 4 дэх хэсгүүд) эрхтэй болгосон нь тухайн байгууллагын үндсэн чиг үүргийг хуулийн агуулгаас өргөтгөөд зогсоогүй сахилгын хороог өөрөө байгуулаж, түүний шийдвэрийг хянаж өөрчлөдөг эрхийг өөртөө авснаараа шүүн таслах ажлалагаанд оролцох боломжтой болжээ.

Монгол Улсын Шүүхийн тухай хуульд Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, Шүүгчид гадаад улсад зорчих, байх хугацаандаа дипломат эрх, ямба, дархан зүх эдлэх тухай заасан нь Монгол улсын нэгдэн орсон олон улсын холбог-

дох конвенцээр зохицуулах харилцааг үндэсний хуулиар зохицуулаад зогсохгүй ийнхүү хуульчлахдаа конвенцийн агуулгыг зөрчсөн байна. Энэ нь үндэсний хууль тогтоомжийг Олон улсын эрх зүйн хэм хэмжээнээс дээгүүр тавиад зогсоогүй бусад улсад өөрийн хуулийг биелүүлэхийг тулгах хандлагатай болжээ.

Үндсэн хуулийн Цэцийн хуралдааны явцад гомдол гаргагч иргэн А. Энхбат, С. Зориг нар сахилгын хорооны шийдвэрт шүүгч шүүхэд гомдол гаргах эрхийг хязгаарласан заалт Үндсэн хуулийг зөрчжээ гэсэн гомдлоосоо татгалзсан тул уг асуудлыг хянан хэлэлцэх шаардлагагүй гэж үзэв.

А. Энхбат, С. Зориг нарын гомдолд буй «Хуулиар шүүхэд харьяалуулсан хэрэг, маргаан гэсэн ойлголт нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасан агуулгатай нийцэхгүй байна» гэсэн хүсэлт нь Монгол Улсын шүүхийн тухай хуулийн талаарх үзэл баримтлалын чанартай зүйл бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн заалттай нийцэж байх тул хүсэлтийг хангах үндэслэлгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйл, Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон гаргах дүгнэлт:

1. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн «Шүүгчийг шилж сонгохтой холбогдож гарсан Ерөнхий зөвлөлийн шийдвэр эцсийнх байна» гэсэн 42-р зүйлийн 2 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн 16-р зүйлийн 14 дэх хэсгийг Шүүхийн ерөнхий зөвлөл Шүүгчдэд сахилгын хэрэг үүсгэх тухай (Шүүхийн тухай хуулийн 47-р зүйлийн 1), Сахилгын шийтгэлд гомдол гаргах, сахилгын шийтгэлийн төрөл сонгох тухай (шүүхийн тухай хуулийн 49-р зүйлийн 3, 4) дэх заалтууд Үндсэн хуулийн 49-р зүйлийн 3, 4 дэх хэсгийн заалтыг, шүүгчид нэр дэвшигчдийг бүртгэх тухай Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 41-р зүйл Үндсэн хуулийн 51-р зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч гадаадад зорчих, байх хугацаандаа дипломат эрх ямба, дархан эрх эдлэх тухай шүүхийн тухай хуулийн 64-р зүйлийн 9 дэх хэсгийн заалт, Үндсэн хуулийн 10-р зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг тус тус зөрчжээ.

2. Иргэн С. Зориг, А. Энхбат нарын «Хуулиар шүүхэд харьяалуулсан хэрэг, маргаан» гэсэн Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалт Үндсэн



хуулийн 16-р дугуйн 14 дэх хэсгийн заалтыг зөрчиж байна гэсэн гэмдлийг Үндсэн хууль зөрчөөгүй гэж үзэж хэрэгсэхгүй болгон.

3. Манай дүгнэлтийг хэрхэн шийдвэрлэсэн тухай хариуг түүнийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор мэдэгдэхийг Улсын Их Хуралд уламжилж байна.

Дарга  
Ганзүүд

Г. НЯМДОО  
А. БААСАН  
Н. ЖАНЦАН  
С. ЖАНЦАН  
Д. ЧИХААЖАВ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ТОГТООЛ

1994 оны 1 дүгээр

сарын 5-ны өдөр

Дугаар 1

Улаанбаатар

ХОТ

СТАТИСТИКИЙН АЖЛЫН ТАЛААР АВАХ  
ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын статистикийн газарт даалгах нь:

а) төр, засгийн төв байгууллагыг макро эдийн засгийн талаархи статистикийн төвлөрсөн мэдээллээр хангах, статистик ажиглалт, тооллого, нэг удаагийн болон түүвэр судалгаа явуулах чигдэлээ жил бүрийн 12 дугаар сарын 1-ний дотор боловсруулан Засгийн газарт оруулж байсугай.

б) зах зээлийн эдийн засгийн хөгжлийн шаардлагатай нийцүүлэн олон улсын статистик мөрлөж буй статистик мэдээллийн системд шилжих хөтөлбөрийн төслийг Сангийн яам, Монгол банктай хамтран боловсруулж 1994 оны 3 дугаар сард багтаан Засгийн газарт оруулсугай.

2. Төр, засгийн байгууллагуудад сар, улирал, жилээр гаргаж өгч байх нийгэм, эдийн засгийн мэдээллийн жагсаалт, мэдээ гаргах хугацааг хавсралтын ёсоор баталсугай.

3. Статистикийн төвлөрсөн мэдээлэл, яам, газрын дотоод мэдээллийн санд байх мэдээллийн үзүүлэлтийг Улсын статистикийн газартай хамтран 1994 оны 1 дүгээр улиралд багтаан гаргахыг яам, газруудад даалгасугай.

4. Хүн амын амьжиргааны түвшингийн өөрчлөлт, өрхийн мөнгөн орлого, зарлага зэрэг нийгмийн асуудлын гол гол үзүүлэлтээр өрхийн аж ахуйн судалгааг 1994 оноос эхлэн нийслэл, аймаг, хотод нийт өрхийн 0,3-аас доошгүй хувийг тэмрүүлэн явуулж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга, хотын Ардын Хуралыг гүйцэтгэх захиргааны дарга нэрт, өрсийн аж ахуйн судалгааг нэгтгэн дүгнэж сар, улирлаар Засгийн газарт мэдээлж байхыг Улсын статистикийн газарт тус тус даалгасугай.

5. Өрхийн аж ахуйн судалгаанд хамрагдах өрхүүдэд урамшил болгон сар бүр 250 төгрөг олгож байхын хамт уг судалгааг гаргахад мэргэжлийн туслалцаа үзүүлэх, мэдээлэл хүлээн авч шалган дамжуулах үүрэг бүхий орон тооны бус мэдээлэгчийг 25 өрхөд нэг байхаар, тэдэнд сард 1500 төгрөгийн урамшил олгож байхаар бодож, судалгааны зэрдлэг тоодон Улсын статистикийн газарт жил бүр олгож байхыг Сангийн нам (Д. ДАВААСАМБУУ)-д даалгасугай.

6. Өмчийн бүх төрөлд хамаарах үйлдвэр, аж ахуйн байгууллагын бүртгэл, тооллого явуулж, тэдгээрт регистрийн дугаар олгох ажлыг 1994 оны 4 дүгээр сарын 1-ний дотор хийхийг Улсын статистикийн газрын дарга, Сангийн сайд нэрт даалгасугай.

7. Энэ тогтоол гарсантай холбогдуулан «Статистикийн ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай» Засгийн газрын 1992 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 30 дугаар тогтоолын 1 дүгээр зүйл, «Өрхийн аж ахуйн судалгаа явуулах тухай» 1991 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 345 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П. ЖАСРАЙ

Монгол Улсын сайд бөгөөд Үндэсний  
хэргийн газрын дарга

Ч. УЛААН

Засгийн газрын 1994 оны 1 дүгээр  
тогтоомын хавсралт

МОНГОЛ УЛСЫН СТАТИСТИКИЙН ГАЗРААС ТӨР,  
ЗАСГИЙН БАЙГУУЛЛАГАД ГАРГАЖ ӨГЧ БАЙХ  
МЭДЭЭЛЛИЙН ЖАГСЛАЛТ, МЭДЭЭ ГАРГАХ ХУГАЦАА

Мэдээллийн үзүүлэлтийн нэр	Мэдээллийг төр, засгийн байгууллагад гаргаж өгөх хугацаа
<b>I. Макро эдийн засгийн үзүүлэлтүүд</b>	
1. Дотоодын нийт бүтээгдэхүүн, түүний өсөлт салбараар	Урьдчилсан гүйцэтгэ- лийг дараа оны 1 дү- гээр сарын 10-нд, эц- сийн гүйцэтгэлийг 4 дүгээр сарын 15-нд
2. Үндэсний нийт бүтээгдэхүүн, нэг хүнд ногдох хэмжээ	—”—
3. Улсын хүн амын тоо, өсөлт аймаг, хотоор	—”—
4. Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо	Дараа оны 3 дугаар сарын 20-нд
5. Ажиллагчдын тоо салбараар	—”—
6. Ажилгүйдлийн тоо аймаг, хотоор	Сар бүрийн 8-нд
7. Хэрэглээний үнийн индекс (хот, хөдөөгөөр ялгаатай)	—”—
8. Мөнгөний ханшны өөрчлөлт	—”—
9. Улсын төвлөрсөн төсвийн орлого (орлогын төрлөөр)	—”—
10. Орон нутгийн төсвийн орлого (орлогын төрлөөр)	—”—
11. Улсын төвлөрсөн төсвийн зар- лага (зарлагын төрлөөр)	—”—
12. Орон нутгийн төсвийн зарлага (зарлагын төрлөөр)	—”—

13. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний хэмжээ	Сар бүрийн 8-нд
14. Хүн амын мөнгөн хадгаламж	—*—
15. Экспорт, импортын гүйцэтгэл (үнийн дүн, биет хэмжигдэхүүнээр)	—*—
16. Экспорт, импортын барааны үнийн индекс	Улирлын дараахь сарын 8-нд
17. Зээл, тусламжийн барааны нийлүүлэлт, зарцуулалт	Улирлын дараахь сарын 8-нд

## II. Нийгмийн статистикийн үзүүлэлтүүд

1. Хүн амын нөхөн үйлдвэрлэлт (төрөлт, нас бараалт)	Сар бүрийн 8-нд
2. Хүн амын шилжих хөдөлгөөн (дотоод, гадаад)	Дараа оны 3 дугаар сарын 8-нд
3. Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо өвчний нэрээр	Сар бүрийн 8-нд
4. Төрсөн эх, хүүхдийн эмдэгдэл	—*—
5. Бүх шатны сургуульд суралцагчдын тоо	Дараа оны 1 дүгээр сарын 8-нд
6. Сургууль завсардсан хүүхдийн тоо	Дараа оны 3 дугаар сарын 8-нд
7. Өрхийн мөнгөн орлого, зарлага, тэдгээрийн бүтэц	Сар бүрийн 8-нд
8. Нэг хүнд ногдох хүнсний зүйлийн хэрэглээ (биет болон мөнгөн илэрхийллээр)	—*—
9. Гэр, орон сууцны мэдээ	Дараа оны 2 дугаар сарын 8-нд
10. Өвчин хүүхдийн тоо	Дараа оны 1 дүгээр сарын 8-нд
11. 16 хүртэлх насны хүүхэдтэй гэр бүлгүй хүний тоо	—*—
12. Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо	—*—

13. Төхир дутуу хүний тоо	Дараа оны 1 дүгээр сарын 8-нд
14. Өрхийн ам бүлийн байдлын мэдээ	— " —
15. Хүн амд үзүүлсэн буцалтгүй тусламж	— " —
16. Тэтгэвэр тогтоогдоогүй болон хүүхдийн тэтгэвэр төлдөг хүний тоо	— " —
17. Тэтгэвэр авдаг хүн, тэдгээрт олгосон тэтгэврийн хэмжээ	— " —
18. Ядуу орх, тэдгээрийн ам бүл, хөдөлмөр эрхлэлт	1, 7 дугаар сарын 8-нд
19. Түгээмэл ажил мэргэжлийн хүмүүсийн сарын дундаж цаалин, хөдөлмөрийн хөлсний судалгаа	— " —
20. Гарсан гэмт хэргийн тоо хэргийн төрлөөр	Сар бүрийн 8-нд

### III. Үйлдвэрлэлийн статистикийн үзүүлэлтүүд

#### Хөдөө аж ахуй

1. Жилийн эцсийн мал тооллогын урьдчилсан дүн	Дараа оны 1 дүгээр сарын 8-нд
2. Мал, тэжээвэр амьтад, ханлаа, худаг, тэжээлийн тооллогын нэгдсэн дүн	Дараа оны 2 дугаар сарын 8-нд
3. Мал төллөлт, төл бойжилт	Улирлын дараахь сарын 8-нд
4. Малын зүй бус хорогдол	— " —
5. Хөдөө аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт	7, 1 дүгээр сарын 8-нд
6. Таривалалт	5—7 дугаар саруудад сар бүрийн 8-нд
7. Хадлан, тэжээл бэлтгэл	9—11 дүгээр саруудад сар бүрийн 8-нд

- |   |                                     |
|---|-------------------------------------|
| 8. Ургац хураалт  | —"                                  |
| 9. Эрт урганын ногоо  | 5—8 дугаар саруудад сар бүрийн 8-нд |
| 10. Жимс, жимсгэнэ  | Дарва оны 1 дүгээр сарын 8-нд       |
| 11. Хөдөө аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүний үнэ, түүний өөрчлөлт | Улирлын дараахь сарын 8-нд          |
| 12. Мах, гурилын үйлдвэрлэлт, хэрэглээний тэнцлийн мэдээ          | —"                                  |

### Аж үйлдвэр

- |   |                               |
|---|-------------------------------|
| 1. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт  | Сар бүрийн 8-нд               |
| 2. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл (биет хэмжигдэхүүнээр)                   | —"                            |
| 3. Аж үйлдвэрийн өртөг, зардлын судалгаа (дэд салбараар)                              | Улирлын дараахь сарын 8-нд    |
| 4. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үнийн индекс (дэд салбар, гол нэрийн бүтээгдэхүүнээр) | —"                            |
| 5. Эрчим хүчний тэнцэл (нахилгаан, дулаан)  | Дарва оны 4 дүгээр сарын 8-нд |
| 6. Нүүрсний тэнцэл  | —"                            |
| 7. Аж үйлдвэрийн газруудын судалгааны дүн   | Дарва оны 3 дугаар сарын 8-нд |

### Барилга

- |   |                            |
|---|----------------------------|
| 1. Ашиглалтад оруулсан барилга, үндсэн фонд                         | Улирлын дараахь сарын 8-нд |
| 2. Барилга угсралт, их засварын ажил, түүний өртөг зардлын судалгаа | —"                         |

### Тээвэр, холбоо

- |                            |                            |
|----------------------------|----------------------------|
| 1. Тээсэн ачаа нэр төрлөөр | Улирлын дараахь сарын 8-нд |
|----------------------------|----------------------------|

2. Зорчигч эргэлт	— " —
3. Тээврийн орлого, зардал, тарифын судалгаа	— " —
4. Холбооны орлого, зардал, тарифын судалгаа	Улирлын дараахь сарын 8-нд

**IV. Байгаль орчин, шинжлэх ухаан, соёлын статистикийн үзүүлэлтүүд**

1. Ойн сангийн мэдээ	Дараа оны 1 дүгээр сарын 8-нд
2. Газрын хөрс хамгаалах арга хэмжээний мэдээ	— " —
3. Ус ашиглалт, гол мөрний бохирдолтын мэдээ	— " —
4. Ан амьтдын тоо, агнуурын мэдээ	— " —
5. Агаарын бохирдлын мэдээ (хотот)	Улирлын дараа сарын 8-нд
6. Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын орлого, зарлага	Дараа оны 3 дугаар сарын 8-нд
7. Эрдэм шинжилгээний ажилтан, эрдмийн зэрэг, цолтой хүний тоо	— " —
8. Эрдэм шинжилгээний ажлын үндсэн үр дүн (төслөөр)	— " —
9. Тогтмол хэвлэгддэг сонин, сэтгүүлийн тоо, эвлэгдсэн хувь	1 дүгээр сарын 8-нд

**ТАЙЛБАР:** 1. Эдгээр үзүүлэлтүүд нь төр, засгийн байгууллагын удирдлага, зохицуулалтад тэргүүн ээлжинд шаардлагатай гэж үзсэн үзүүлэлтүүд бөгөөд улсын мэдээ, тайлангаар авдаг бусад үзүүлэлтүүд урьдын адил гарч, эдгээр нь зах зээлийн нөхцөлд зохицсон үзүүлэлтүүдээр нөхөн сэлбэгдэж байнга өөрчлөгдөж байх юм.



2. Статистикийн газраас төр, засгийн ббайгууллагын захиалгын дагуу нэг удаагийн тооллого, түүнээр судалгааг тусгай программ, үзүүлэлтүүдээр явуулж байхх болно.

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

1993 оны 12 дугаар  
сарын 27-ны өдөр

Дугаар 55

Улаанбаатар  
хот

### ШҮҮХИЙГ МЭРГЭЖЛИЙН УДИРДЛАГААР ХАНГАХ ЖУРМЫН ТУХАЙ

Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Монгол Улсын шүүхийг дор дурдсан журмаар мэргэжлийн удирдлагаар хангах журмыг хавсралтын дагуу баталсугай.

2. Энэхүү журмыг Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн дэвж эзлэхэд шатны шүүх доод шатны шүүхүүхээ мэргэжлийн удирдлагаар хангах бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ дагаж мөрдөхөөр тогтоосугай.

3. Бүх шатны шүүхийн ерөнхий шүүгч, шүүгчдээс энэ журамд заасан үүргээ хэрхэн биелүүлж байгаад шүүхийн ажлыг шалган туслах ажлын хамт хянан шалгаж байхыг бүх шатны шүүхийн ерөнхий шүүгчдэд даалгасугай.

Ерөнхий шүүгч

Д. ДЭМБЭРЭЛЦЭРЭН

Монгол Улсын Дээд шүүхийн 1993  
оны 12 дугаар сарын 27-ны өдөр  
55 дугаар тогтоолын хансралт

## ШҮҮХИЙГ МЭРГЭЖЛИЙН УДИРДААГААР ХАНГАХ ЖУРАМ

### НЭГ. Нийтлэг үндэслэл

1. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 24-р зүйлийн 3 дахь хэсгийн 1-д зааснаар Монгол Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн давж заалдах шатны шүүх нь доод шатны шүүхээ мэргэжлийн удирдлагаар хангах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

2. Монгол Улсын Шүүхийн тухай хуульд заасан хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнийг томилж ерөнхий шүүгчийн бүрэн эрх нь шүүгчдийг мэргэжлийн удирдлагаар хангах ажлыг багтаана.

3. Шүүхийн мэргэжлийн удирдлага нь доод шатны шүүхээс тодорхой хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд хөндлөнгөөс нь оролцохгүйгээр хуулийг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх, хэрэг маргааныг үнэн зөв, шударгаар шийдвэрлэх, шүүн таслах ажиллагаанд нэгдсэн практик тогтоох зорилгоор шүүгчдэд шүүн таслах ажиллагааны мэдлэг, ур чадвар, дадлага эзэмшүүлэх, холбогдох хууль тогтоомж, гарын авлага, арга зүйн удирдлага, мэдээллээр хангах, шүүн таслах ажиллагааны алдаа, дутагдлыг илрүүлэн арилгах арга хэмжээний цогц мөн.

### ХОЕР. Мэргэжлийн удирдлагын хэлбэр

4. Шүүхийг мэргэжлийн удирдлагаар хангах ажил нь доорх хэлбэртэй байж болно:

- 1) хууль тайлбарлах;
- 2) тодорхой хэрэг хянан шийдвэрлэх;
- 3) энгийн магадлал бичих;
- 4) шалган туслах;
- 5) шүүхийн шийдвэрийг хянах;
- 6) сургаат явуулах;
- 7) шүүхийн практикийг нэгтгэн судалж зөвлөмж, зөм  
гаргах
- 8) бусад

ГУРАВ. Тодорхой хэлбэрийн мэргэжлийн  
удирдлагаар хангах журам

А. Хууль тайлбарлах

5. Хууль тогтоомжийн заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Дээд шүүх хуулийн албан ёсны тайлбар гаргана. Тайлбарыг хууль тогтоох байгууллагын шийдвэр, төрийн захиргаа, хууль хамгаалах төв байгууллага, тусгай газар, тэдгээрийн удирдах албан тушаалтан, шүүх, шүүх судлалын төвийн санал буюу өөрийн болон Дээд шүүхийн шүүгчийн саналчилгаар боловсруулна. Хуулийн тайлбар боловсруулах ажлыг Монгол Улсын Дээд шүүхийн ерөнхий шүүгч зохицуулан зохион байгуулна.

6. Тайлбарын төслийг Дээд шүүхийн ерөнхий шүүгчийн томилсон шүүгч буюу ажлын хэсэг боловсруулна. Томилсон шүүгч, ажлын хэсэг төслийг боловсруулахдаа түүний эрх зүйн онолын үндэслэл, тухайн хуулийг хэлэлцэн баталсан явц, хэрэглэж байгаа практикийг судалж, шаардлагатай бол мэргэжлийн комиссын дүгнэлт гаргуулна.

7. Төслийн анхны хувилбарыг боловсруулсны дараа шаардлагатай бол түүнийг Дээд шүүхийн шүүгчид, бусад шүүх, шүүгчид, сургалт-эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэд, хуульчид, мэргэжлийн төв байгууллагууд, тэдгээрийн ажилтай, Ерөнхий прокурорын газарт хүргүүлэн саналыг бичгээр авч нэгтгэн дахин боловсруулна.

8. Тайлбарын төслийг боловсруулж байгаа шүүгч, ажлын хэсэг нь тайлбарын нэлтгэлийг нэгэн зэрэг бэлтгэнэ. Илтгэлд тухайн хуулийг тайлбарлах шаардлага, түүний дотор хэрэглэж байгаа практик, түүний ололт дутагдал, төсөл боловсруулалтын явц, бусад байгууллага, албан тушаалтны санал, тайлбарын онол, практикийн үндэслэлийг тодорхой тусгасан байна.

9. Тайлбарын төслийг Дээд шүүхийн хуралдаанаар хэлэлцүүлж батална.

Төслийг хуралдаанаар хэлэлцэн батлах, ёсчлох журмыг Дээд шүүхийн хуралдааны дэгээр зохицуулна.

10. Дээд шүүхийн тайлбарыг тогтоолын хэлбэрээр гаргана. Энэхүү тогтоолыг Шүүхийн тамгын газар, (Дээд шүүхийн хуралдааны нарийн бичгийн дарга) эрхлэн дараах байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ:

1) аймаг, нийслэлийн давж заалдах шатны шүүх

- 2) Ерөнхий прокурорын газар
- 3) Цагдаагийн ерөнхий газар
- 4) Монголын өмгөөлөгчдийн холбооны тэргүүлэгчид
- 5) Төрийн мэдээлэл сэнгүүд, Шүүхийн бичиг сонин редакци
- 6) тайлбарласан хуулийг хэрэглэх гол салбарын төв байгууллага
- 7) МУУИС-ийн хууль зүйн салбар
- 8) шаардлагатай бусад байгууллага, албан тушаалтан

11. Дээд шүүхийн тайлбарыг хүлээн авмагц нийт шүүгчид, холбогдох ажилтнуудаар нэг бүрчлэн судлуулах арга хэмжээг аймаг, нийслэлийн болон сумын буюу сум дундын, дүүргийн шүүхийн ерөнхий шүүгч зохион байгуулна.

#### Б. Тодорхой хэрэг хянан шийдвэрлэх

12. Эрүү, иргэний тодорхой хэргийг хянан шийдвэрлэсэн Дээд шүүхийн болон аймаг, нийслэлийн давж заалдах шатны шүүхийн шийдвэр нь тухайн төрлийн хэргийн байдлыг зөв үнэлэн дүгнэх, зүйлчлэх, хууль ёсны шударга шийдвэр гаргах, шүүхийг мэргэжлийн удирдлагаар хангах байнгын гол хэлбэр болно. Энэхүү шийдвэрт дээр дурдсан шүүхүүдийн анхан шатны давж заалдах болон хяналтын шатны шийдвэр (таслан шийдвэрлэх тогтоол, шийдвэр, магадлал, тогтоол) эргэн адна хамаарна.

13. Дээд шүүх, аймаг, нийслэлийн давж заалдах шатны шүүх шийдвэр гаргахдаа түүний хэлбэр, түүнд тавигдах шаардлага, гаргах журмын талаар байцаан шийтгэх хуулийн шаардлагыг чанд баримтална.

14. Дээд шүүх, аймаг, нийслэлийн давж заалдах шатны шүүх шийдвэртээ тухайн хэрэг байдлыг нотлох баримтаар бүрэн тогтоосон эсэх, нотлох баримтууд нь хуулийн шаардлага хангасан эсэх, шүүх хэргийн байдлыг зөв үнэлэн дүгнэж зөв зүйлчилсэн эсэх, шүүхийн шийдвэр хууль ёсны үндэслэлтэй эсэх, шүүх шийдвэрээ нотлох баримтаар бүрэн зөв үндэслэсэн эсэх, шүүхийн шийдвэр хэлбэрийн сульд хуулийн шаардлага хангасан эсэхийг зааж доод шатны шүүхийн алдаа, дутагдал, түүний шалтгаан, арилгах аргыг замыг бүрэн заасан байвал зохино.

15. Тодорхой хэрэг дээд шатны шүүхээр хянагдан шүүхийн шийдвэр өөрчлөгдсөн буюу хүчингүй болсон тохиолдол бүрт тухайн хэргийг шийдвэрлэсэн шүүгч дээд шатны шүүхийн шийдвэрийг заавал судлан өөрийн үйл ажиллагаанд дүгнэлт хийнэ. Шаардлагатай бол тухайн шүүхийн нийт шүүгч судалж болно.

16. Хуулийг зөв хэрэглэх, шүүхийн нэгдсэн практик тогтооход удирдамжийн ач холбогдолтой гэж үзсэн Дээд шүүх, аймаг, нийслэлийн дэвж заалдах шатны шүүхийн шийдвэрийг нийт шүүхэд хүргүүлж судлуулах буюу эмхтгэл болгон хэвлэж болно. Энэ шийдвэр нь удирдамжийн чанартай эсэхийг Дээд шүүхийн дэргэдэх шүүхийн судалгааны төвд тухайн хэргийг хянан шийдвэрлэсэн шүүх бүрэлдэхүүний саналыг үндэслэн Дээд шүүхийн ерөнхий шүүгч шийдвэрлэнэ. Удирдамжийн чанартай шүүхийн шийдвэрийн санг Шүүхийн судалгааны төв эрхлэн, шийдвэрийг ангилан хадгалж бөгөөд энэ нь шүүхээс хэрэг шийдвэрлэх, тайлбар гаргах шүүн таслах баримт бичгийн сан болно.

### В. Эргийн магадлал бичих

17. Шүүхээс шүүн таслах ажиглагчийн явцад гаргасан алдаа, зөрчил, тэдгээрийн шалтгааныг арилгуулах, дахин гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор дээд шатны шүүх эргийн магадлал гаргаж болно. Эргийн магадлал дурдсан алдаа, зөрчлийн шинж чанараас шалтгаалан түүнийг гаргасан шүүх бүрэлдэхүүний шийдвэрээр тухайн хэргийг хянан шийдвэрлэсэн шүүх, шүүгчээс гадна нийт шүүхэд хүргүүлж болно.

18. Эргийн магадлал гаргах, түүний мөрөөр арга хэмжээ авах, харну өгөх журмыг байцаан шийтгэх хуудлар зохицуулна.

### Г. Шалган туслах

19. Доод шатны шүүхийн шүүн таслах ажиглагчид үнэлэлт дүгнэлт өгөх, түүний олоолтыг баталгах, алдаа дутагдал тэдгээрийн шалтгааныг илрүүлэн арилгах, шүүгчдийг хууль хэрэглэх, шүүхийн баримт бичиг боловсруулах ур чадварыг дээшлүүлэх, шүүхийн нэгдсэн практик тогтоох зорилгоор шалган туслах арга хэмжээ авч байна.

20. Шалган туслах ажил нь иж бүрэн буюу хэсэгчилсэн байа болох бөгөөд нийт шүүхийг тодорхой хугацаанд хамарч байвал зохино. Шалган туслах ажилыг эрх бүхий байгууллага, албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу явуулна.

### Д. Шүүхийн шийдвэрийг хянах

21. Шүүхийн шүүн таслах ажиглагчийн алдаа зөрчлийг цаг тухайд нь илрүүлэн арилгах, шүүхийн алдаанаас шүүг-

дэгч, хохирогч, зохигчид болон бусад иргэд, аж ахуйн нээгч байгууллагад хууль бус хохирол учрах боломжийг хаах зорилгоор аймаг, нийслэлийн давж заалдах шатны шүүх. Дээд шүүх доод шатны шүүхийн шийдвэрийг (таслан шийдвэрлэх тогтоол, шийдвэр, магадлал,) хянаж байна.

22. Шүүхийн тухайн шийдвэрт гомдол гарсан, эсэргүүцэл бичсэн бол түүнийг байцаан шийтгэх хуульд заасан журмаар шийдвэрлэнэ. Хэрэв гомдол гараагүй, эсэргүүцэл бичигдээгүй бол сумын буюу сум дундын, дүүргийн шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол, шийдвэр, магадлалыг аймаг, нийслэлийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгч, аймаг, нийслэлийн шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол, шийдвэр, магадлал (II шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэснийг оролцуулан) Дээд шүүхийн шүүгч шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш нэг бүрчлэн тусгай бүртгэлээр хянана.

23. Хэрэв шүүн таслах ажиллагаандаа хууль зөрчсөн алдаа, дутагдал гаргасан бол шийдвэрийг хянасан шүүгч, ерөнхий шүүгч хуульд заасны дагуу эсэргүүцэл бичих буюу эсэргүүцэл бичих эрх бүхий шүүгчид саналда хэргийн материалын хамт хүргүүлнэ. Эрх бүхий шүүх саналыг хүлээн авмагц хэргийг хянан хуулийн дагуу шийдвэрлэнэ.

24. Тухайн шүүхийн шийдвэрийг дээд шатны шүүхэд түүнийг гаргаснаас хойш 10 хоногийн дотор хүргүүлэх үүргийг аймаг, нийслэлийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгч, сумын буюу сум дундын дүүргийн шүүхийн ерөнхий шүүгч хүлээнэ.

### Е. Сургаал явуулах

25. Шүүгчдийн мэргэжлийг дээшлүүлэн хууль хэрэглэх, шүүхийн баримт боловсруулах мэдлэг, ур чадвар, даллагыг дээшлүүлэх зорилгоор шүүгчдийн сургаал явуулна. Сургалтын хэлбэр, зохион байгуулалт, журмыг Монгол Улсын шүүхийн шүүгчдийн мэргэжлийг дээшлүүлэх, дэвтэн сургах үндсэн чиглэл, дүрмүүдээр тодорхойлно.

Ж. Шүүхийн практикийг нэгтгэн судалж, тойм зөвлөмж бичих

26. Шүүн таслах ажиллагааны хандлагыг тодорхойлох, нийтлэг алдаа дутагдлыг илрүүлэн арилах, шүүхийн нэгдсэн практик тогтоох, хуулийг зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор зөвлөмж, тойм гаргана. Зөвлөмж, тоймын үндэс нь

шүүхийн практикийг эрх зүйн салбар, дэд салбар, хуулийг бүлэг, зүйлээр буюу тодорхой шүүхээр нэгтгэн судалсан дүн болно.

27. Судалгааг Шүүхийн судалгааны төв, Дээд шүүхийн шүүгчид, бусад ажилтнууд жил, удирлын төлөвлөгөөний дагуу дангаараа буюу бусад байгууллага, тэдгээрийн ажилтнуудтай хамтран явуулна. Хэрэв Дээд шүүхийн шүүгч судалгааны ажилд оролцож байгаа бол ажлын зохицуулагч нь Дээд шүүхийн шүүгч байна.

28. Судалгааны дүнг нилээдэн тойм, зөвлөмжийг боловсруулсны дараа Шүүхийн судалгааны төвийн удирдлага, Дээд шүүхийн хуралдаанаар дангаар буюу зохих бусад байгууллагатай хамтран хэлэлцүүлж зөвшөөрүүлэн шүүхүүдэд хүргүүлнэ. Ийнхүү зөвшөөрүүлсэн тойм, зөвлөмжийг шүүн таслах ажлын бодлого боловсруулах, тайлбар гаргахад ашиглаж болно. Тойм, зөвлөмжийг хүлээн авмагц нийт шүүгчид, бусад ажилтнуудаар нэг бүрчлэн судлуулж, ярицлага зохиох үүргийг аймаг, нийслэлийн шүүхийн ерөнхий шүүгчид хүлээнэ.

29. Дээд шүүхийн дэргэдэх шүүхийн судалгааны төв судалгаа хийх журмыг уг төвийн тухай дүрмээр тодорхойлно.

### 3. Бусад хэлбэр

30. Шүүхийг мэргэжлийн удирдлагаар хангах ажлын бусад хэлбэрт нийтлэл бичих, шүүн таслах ажлын онол-практикийн хурал хийх, ярицлага, лекц зохион байгуулах, үзүүлэх шүүх хуралдаан зохион байгуулах болон бусад ажил багтана.

31. Шүүн таслах ажиллагааны талаар судалгаа хийн, хуулийг нэг мөр ойлгон, зөв хэрэглэх, шүүн таслах ажлын нэгдсэн практик тогтоох, хуулийг тайлбарлан таниулах онол-практикийн асуудлаар нийтлэл бичих нь бүх шатны шүүхийн шүүгчид ялангуяа Дээд шүүх, аймаг, нийслэлийн давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн мэргэжлийн үүрэг мөн.

32. Нийтлэл нь өгүүдэл, хууль, шүүхийн шийдвэрийн тайлбар, асуултын хариу, ярицлага, болон бусад хэлбэртэй, хэвлэл, радио, телевизэд зориулсан байж болно.

33. Нийтлэл бичих ажлыг тухайн шүүхийн ерөнхий шүүгч, хэвлэлийн төлөөлөгч зохион байгуулна.

34. Шүүхийг мэргэжлийн удирдлагаар хангах бусад хэлбэрийн ажлыг бүх шатны шүүхийн ерөнхий шүүгч зохиуулан зохион байгуулна.

## БАНКНЫ ХУУЛЬД ЗАРИМ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАЛААР

Монголбанкнаас төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх явцад Банкны хуулийн зарим зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай болж Монгол Улсын «Банкны хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай» хууль 1993 оны 11 дүгээр сарын 18-нд батлагдлаа.

Энэ хуулиар Банкны хуулийн гэд хэдэн зүйлийг өөрчлөн найруулснаас гадна шинээр 4 зүйл 7 заалт нэмж, 2 зүйлд найруулгын өөрчлөлт оруулав.

1. Орон нутгийн Монголбанкны салбарт байгаа төсвийн дансан дахь хөрөнгийг Монгол Улсын Төсвийн Төслийн тухай хууль болон бусад хуультай нийцүүлэн төсвийн эрх захиралч захиран зарцуулж байхаар оруулснаар Банк санхүүгийн байгууллагын хооронд гардаг төсвийн орлого зарлагыг шилжүүлэхтэй холбоотой маргааныг шийдвэрлэх бололцоотой болгоо.

2. Мөн 4 дүгээр зүйлийн 9 дэх заалтыг «Хууль тогтоомжоор хориглоогүй, Монголбанкнаас зөвшөөрсөн бусад гүйлгээ» гэж өөрчлөн найруулсан нь шинээр гарч байгаа хуулиудад тусгайлан хориглоогүй э бол ямар ч гүйлгээг хийж болох мэтээр ойлгогдож байсан банкны нэр хүнд, харилцагчдын эрх ашигт сөрөг нөлөө бүхий гүйлгээ, үйл ажиллагааг журамлаж, төрийн мөнгөний бодлого, бусад хууль тогтоомжид нийцүүлэн зөвхөн Монголбанкнаас зөвшөөрсөн гүйлгээг хийж болно гэж хуульчлан залл.

3. Заавал байх нөөц нь арилжааны банкуудын хувьд нэг төрлийн «гатаар» бөгөөд энэ нөөцөөр дамжуулан мөнгөний шилжүүлэлтийг зохицуулж төгрөгийн тогтвортой байдлыг хангах, инфляци үнийн осолтийг сааруулах хөшүүрэг болгон ашигладаг. Банкны хуулийн 14 дүгээр зүйлд заавал байх нөөцөд тухайн банкны кассад байгаа бэлэн үлдэгдэл мөнгийг тооцно гэж заасан нь чөлөөт валютын зах дөнгөж эхлэн хөгжиж байгаа манай орны нөхцөлд тухайн банк харилцагчийн анхны шаардлагыг биелүүлэх боломжгүй болгож байлаа. Мөн нөгөө талаас заавал байх нөөцийн хувь хэмжээг тогтоосон хэмжээнд байлгаагүй арилжааны банкнд ногдуулах хүү, торгуулийн хэмжээг хуульчлан тогтоогоогүй зэрэг шалтгаанаас болж уг заалт амьдраад биеллээ олсонгүй. Иймээс хуульд заавал байх нөөцөд чухам ямар дансыг



оргуулалт тооцохыг нэг бүрчлэн тооцогүйгээр Монголбанк өөрийн тушаал, заавраар зохицуулж байх боломжтой болгож энэ зөрчмөн дагуу өөрчлөлт оруулсан юм.

4. Банкны хууль тогтоомж зөрчигчдэд хүлээлгэх хариуцлага суларч, саалин задгай, замбараагүй байдал хавтгайрснаас харилцагч байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн эрх ашгийг хохироох явдал газар авч төлбөр тооцооны барамтыг дарагдуулах буюу гүйлгээг саатуулах, тайлан тэнцэл, мэдээ баримтыг цаг хугацаанд зохих журмын дагуу гаргаж өгөхгүй байх, банкны бус байгууллага Монголбанкны зөвшөөрөлгүйгээр банкны үйл ажиллагаа эрхлэх зэрэг зөрчил гарч байгааг арилах, улмаар нийм үзэгдлийг цаашид гаргуулахгүй байх зорилгоор энэ талаар тодорхой бус, хэт ерөнхий заасан хуулийн 44 дүгээр зүйлийг «Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай» хуулийн 176 дугаар зүйлд заасан эрүүгийн хариуцлагаас бусад зөрчлийг банкны тухай хууль тогтоомжийг зөрчсөнд тооцон хариуцлага хүлээлгэхээр нарийвчлэн зааж, (Монголбанкны дүрмийн 22 дугаар зүйлийн 8 дугаар заалтыг тусгаж) хууль тогтоомж зөрчигчдэд Монгол Улсын Захиргааны хариуцлагын тухай хуулийн торгуулийн хувь хэмжээтэй уялдуулан шийтгэл нөсдүүлж байхаар орууллаа.

5. Бэлэн мөнгө, барааны хомсдолыг далимдуулан банкны бус байгууллагаас банктэй ижил төстэй үйл ажиллагаа эрхэлж байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг хохироож байгааг болидуулах зорилгоор 3 дугаар зүйлийн заалтыг шинээр нэмж банкны үйл ажиллагааг зөвхөн Монголбанкнаас зөвшөөрөл авч, улсын бүртгэлд бүртгүүлсэн банк эрхэлж байхыг хуульчлан тусгасан юм.

6. Улсын Их Хуралд Монголбанк ажлаа мэдээлэх, тайлагнах талаар Монголбанкны Дүрэмд тодорхой тусгагдсан боловч Монголбанкны Ерөнхийлөгчийн эрх хэмжээ, түүний баталгааны талаар хуульчилсан эрхийн акт байхгүй байлаа. Иймээс Монгол Улсын Засгийн газрын хуульд заасан Засгийн газрын гишүүдийн эрх хэмжээтэй нийцүүлэн Монголбанкны Ерөнхийлөгчийн бүрэн эрх, түүний баталгаа гэсэн шинэ зүйл нэмлээ.

7. Банкны дүрэмд зайлшгүй тусгагдах шаардлагатай зарим асуудлыг Банкны хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтад нэмлээ. Тухайлбал банкны дүрэмд хувь нийлүүдэгчдийн хурал хуралдах болон төлөөлөн удирдах зөвлөлөөс үйл ажиллагаа явуулах журмыг заавал тусгаж

байхаар болов. Ингэснээр банк байгуулагч, хувь нийлүүлэгчдийн үүрэг харилцаага, банкны зохион байгуулалтын бүтцийг тодорхой болгож, тухайн банкны талаар маргаантай асуудал гарсан нөхцөлд дүрмийн нь дагуу шуурхай шийдвэрлэх (болцоо олгох юм.

8. Хуулийн 35 дугаар зүйлд зарчмын хэд хэдэн загалт шинээр нэмлээ. Үүнд:

— Бليкууд эх үүсвэрээс хэтрүүлэн зээл олгосноос төлбөрийн чадвар нь доройтох, улмаар мөнгөний нийлүүлэлтийг зохиомлоор нэмэгдүүлж, үнэ, ханшид сөрөг нөлөө үзүүлэх, харилцагчдын анхны шаардлагыг биелүүлж чадахгүй банкны үйл ажиллагааны нэр хүндийг бууруулж байгааг арилгах зорилгоор «Эх үүсвэртээ багтаан зээл олгоно» гэж хуульчлан тусгав. Энэ заалтыг биелүүлэхгүй байх нь арилжааны банкны хувьд хууль бус ажиллагаа болно;

— Арилжааны банкны төлбөрийн чадвар, үйл ажиллагааны үр дүнг нь илэрхийлэх шалгуур үзүүлэлтийг Монголбанкнаас тогтоон өгч байх, түүнийг хангаж ажлалах үүрэгтэй гэдгийг арилжааны банкинд хуулиар хүлээлгэлээ;

— Мөн харилцагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор «хуульд зааснаас бусад тохиолдолд харилцагчийн зөвшөөрөлгүйгээр харилцах данснаас гүйлгээ хийхгүй байна» гэсэн заалтыг шинээр тус тус нэмлээ. Арилжааны банкинд дээр төлбөрийн баримт саатах дутагдал түгээмэл байгааг харгалзан «харилцагчийн гүйлгээг гүйлгээ хийх өдөрт нь багтаан гүйцэтгэнэ» гэж эзлсэн юм.

9. Арилжааны банк төлбөрийн чадварын хувьд хүдрэмд орж дамнуурч болзошгүй болсон тохиолдолд Монголбанкнаас бүрэн эрхт төлөөлөгч томилж түүний хяналтан дор тухайн банкны үйл ажиллагааг явуулж байх болсон нь нэг талаас харилцагчийн эрх ашгийг хамгаалсан, нөгөө талаас банкыг дамнуурлаас сэргийлж, түүний нэр хүндийг хамгаалахад чиглэгджээ. Уг заалт нь Монголбанкны дүрэмд тусгагдсан байдаг боловч түүнийг Банкны хуульд оруулах нь дээрх шалтгаанаар зайлшгүй шаардлагатай болов.

10. Орчин үеийн Төв банкны үндсэн үүргийн нэг хэлбэр болох хяналт шалгалтын талаар дэлгэрүүлэн тусгаснаар хяналт шалгалтын цар хүрээ, шалгалтыг гүйцэтгэх субъектын эрх хэмжээг тодорхой болгож, Монголбанк хянан шалгах эрхээ хэрэгжүүлэхдээ арилжааны банкны бие даасан байдлыг алдагдуулахгүй байх зарчмыг баримтлах болэмжтой

болгосноос гадна Монголбайнгны хянан шалгагч нарыг улсын хянан шалгагчийн нэгэн адил эрх хэмжээ, үүрэгтэй болгосноор хяналт шалгалтын ажлыг сайжруулах, шалгалтын үр дүнг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой боллоо.

Улсын Их Хурлын гишүүн Д. ДАНЗАН

## ХОТ, ТОСГОНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛИЙН ТАЛААР

Монгол Улсын Үндсэн хуулинд зарчмын ач холбогдол бүхий шинээр тусгагдсан чухал заалтын нэг нь тус улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны эрх зүйн үндсийг хуулиар тогтоохоор оруулсан явдал юм. Тус улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн явцад шинээр олон тооны хот, тосгон үүсч бий болсон боловч тэдгээрийн нийгэмд эзлэх байр суурь, эрх хэмжээ, үйл ажиллагааг хуульчлан тогтоох асуудал өнөө хүртэл орхигдож ирсний дээр энэ талаар нэгдсэн ойлголт, шинжижгээ судалгааны нэгцтэй материал, нэгтгэн дүгнэсэн арга туршлага хомс бас манай улсын тухайд нийгмийн амьдралын өнөрмөц онцлогоос шалтгаалан гадаадын туршлагыг шууд авч хэрэглэх бололцоо муутай байсан зэрэг нь уг хуулийг боловсруулах, хэлэлцэж батлахад ч багагүй бэрхшээлтэй байсны дээр цаашид амьдралд хэрэгжүүлэхэд ихээхэн ухаалаг хандлагыг зүй ёсоор шаардаж байгаа юм.

Энэхүү хуулийн гол зорилго бол Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн дээс, хот, тосгон тэдгээрийн нийгэм, эдийн засгийн үндэс, удирдлагын үйл ажиллагааны зарчим, тогтолцоо, бүрэн эрхийг тодорхойлж, хот тосгоны удирдлагаас засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага болон аж ахуйн нэгж, байгууллага, оршин суугчидтай харилцах харьцааг зохицуулахад чиглэж байна.

Уг хууль нь 7 бүлэг, 34 зүйлээс бүрдэж байгаа бөгөөд дотроо зүйл тус бүрийг нарийвчлан задалсан хэд хэдэн звалтуудтайгаар хийгдсэн болно.

Ийнхэд үндэслэл гэсэн бүлгийн дотор хот, тосгон гэж юу болох, тэдгээрийн эрх зүйн баталгаа, бүтэн, чиглэл, зэрэглэл, засаг захиргааны харьяалал, эдэлбэр газар, аж ахуй, хөрөнгийн сан гэсэн ойлголтууд багтаж байна. Энд хот, тосгоныг тэдгээрийн оршин суугчдын тоо, улсын болон тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хөгжилд гүйцэтгэх үүрэг ач холбогдол, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын чиглэл, хот бүрдүүлэгч дэд бүтцийн байдлыг харгалзан хот ба тосгон гэж ангилж юм. Тэр нь дотроо улсын ба аймгийн зэрэглэлтэй байхаар зааж зэрэглэл тогтоох арга хэлбэрийг тодорхойлж өгсөн байна.

Уг хуулинд Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтын дагуу хот, тосгон нь засаг захиргааны хувьд оршин байгаа тухайн аймаг, суманд харьяалагдахаар тусгагдсан бөгөөд тусгайлан олгогдсон эдэлбэр газартай, оршин суугчдын нийгэм-эдийн засаг, ахуй, соёлын хэрэгнээг хангах, бие даасан аж ахуйтай, удирдлагын болон хөгжлийн, санхүүгийн үндэс болсон хөрөнгийн сантай байх эрхийг хуульчлан тогтоож өгөн.

Энэ хуулийн нэлээд шинэцэг өөрмөц тал нь хот, тосгоны удирдлагын үндсэн зарчмыг шинэ нөхцөл байдалд зохицуулан тогтоож өгөх явдал байсан бөгөөд ийнхүү хот, тосгоны удирдлага нь захирагч, зөвлөлөөс бүрдэх бөгөөд захирагч нь өдөр тутмын үйл ажыглагааг удирдан зохицуулах үүрэг хүлээж, Зөвлөлийг хот, тосгоны аж ахуйн нэгж, байгууллагын болон ажлын албаны хүмүүсийн бүрэлдэхүүнтэй байгуулж захирагч тэргүүлэхээр тусгасан байна. Мөн энд шаардлагатай гэж үзвэл аймаг, сум, багийн төв болох хот, тосгоны хувьд Засаг дарга, захирагчийн үүргийг нэг хүн гүйцэтгэж байхаар заасан юм.

Ардчилсан зарчимд нийцүүлэн хот, тосгоны захирагчийг тухайн хот, тосгоны сонгуулийн эрх бүхий оршин суугчид 4 жилийн хугацаатайгаар шууд сонгохоор зааж улмаар сонгууль явуулах, захирагчийг чөлөөлөх, огцруулах журам, зарчмыг тогтоосон байна. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулинд Засаг даргын бүрэн эрхийн талаар заасан заалтыг хот, тосгоны удирдлагын хүрээнд хэрэгжүүлэх онцлог арга замыг 3 дугаар бүлэгт нэлээд өөрмөц байдлаар авч үзсэн бөгөөд хот, тосгоны захирагчийн бүрэн эрхийг дотор нь төлөвлөлт, төсөв санхүүгийн, өөрийн мэдлийн өмчийг захиран зарцуулах, аж ахуйн нэгж, байгууллагагай харилцах, газар ашиглах болон байгаль хамгаа-

лах, ер-өн сууц нийтийн аж ахуй ба худалдаа үйлчилжээний талаарж, барилга, тээвэр, холбооны талаарх гэх мэтээр салбаруудад нь ангилж тодруулсан юм. Мөн энд хот, тосгоны захиралгчийн гаргах шийдвэр, түүний бүрэн эрхийг баталгаажуулах асуудалд хуулийн 4 дүгээр бүлэг чйгээгдэж байна. Хуулинд тусгагдсан бас нэг шинэлэг асуудал нь хот, тосгоны оршин суугчид ямар эрх үүрэгтэй байх талаар бие даасан бүлэг оруулж өссөн явдал мөн.

Хот, тосгоны удирдлагаас төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагатай харилцах харилцааг зөв зохицуулах нь уг хуулийн нэлээд нарийн, эмзэг асуудал бөгөөд энд хот, тосгоны бие даасан, чөлөөтэй үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжийг хангахын хэрэгцээ төрийн захиргааны төв ба нутгийн захиргааны байгууллагын эрх ашгийг хохироохгүй байх хамтач нөхөрөөг ажиллагааг аль болох хэрэгжүүлж, заасан эрх хэмжээнийхээ дотор гарсан шийдвэрийг харилцан хүндэтгэн хэрэгжүүлэх нөхцөл байдлыг бүрдүүлэх, үүссэн маргааныг яаж шийдвэрлэх талаар 6 дугаар бүлэг тодорхой хариулт өгч байна.

Хуулийн эцсийн бүлэгт хотын өөрийн амьдралд шаардлагатай зарим заалтыг бусад зүйл гэсэн нэрийн дор оруулж хуулийг бүхэлд нь 1994 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөхөөр заалаа.

Ийнхүү хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль батлагдан гарснаар нийгмийн харилцааны нэг чухал салбар эрх зүйн баталгаатай болж тус улсын дэвшил хөгжлийн зайлшгүй үе дагавар болох хот, тосгон үүсч хөгжих тэдгээрийн нийгэм, эдийн засгийн байр суурийг бэхжүүлэхэд чухал хувь нэмэр болох нь зүйн хэрэг юм.

Энэ хуулийн зүйл ангийг амьдралд хэрэгжүүлэх асуудал нь түүнийг сайтар судалж мэдэх, хэрэглэх арга хэлбэрийг зөв олж оновчтой шийдвэрлэх явдлаас ихээхэн шалтгаалах бөгөөд амьдралаар аяндаа шалгагдаж улам баяжиж сайжрах нь дамжиггүй.

Улсын Их Хурлын гишүүн Д. БАТБААТАР

## МОНГОЛ УЛСЫН ИРГЭН ГАДААДАД ХУВИЙН ХЭРГЭЭР ЗОРЧИХ, ЦАГААЧЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАЛААР

Монгол Улсын Үндсэн хуулийн хоёрдугаар бүлгийн 16-дугаар зүйлийн 18 дахь заалтад Монгол Улсын иргэн «... гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно.» хэмээн заасан юм.

Монгол Улсын Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрч тунхагласан хүний эрх, эрх чөлөөг эрх зүйн баталгаатай болгох, энэ талаар амьдралаар урган гарсан тулгамдсан асуултад хариулах, Монгол Улсын хууль тогтоомжийг олон улсын эрх зүйн актуудтай нийцүүлэх нь «Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай» хуулийг гаргах бодит шаардлага болсон юм.

Тус хуулийн зорилго нь Монгол Улсын иргэн гадаадад зөвхөн хувийн хэргээр зорчих ба цагаачлах, эх орондоо буцаж ирэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Албан ажлаар гадаадад зорчих, буцаж ирэхтэй холбогдсон харилцаа, гадаадад суугаа Монгол Улсын дипломат төлөөлөгчийн байгууллагын ажилтнуудын зорчих явахтай холбогдсон асуудал уг хуульд хамаарахгүй юм.

Хуулийн ач холбогдол доорхи зүйлд оршино. Үүнд:

а) Монгол Улсын Үндсэн хуулиар тунхаглан хүлээн зөвшөөрсөн хүний эрхийг эрх зүйн тодорхой баталгаатай болгосон;

б) тус хуулийг НҮБ-аас баталсан «Хүний эрхийн түгээмэл тунхаглал», Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын (МОТ) конвенцууд зэрэг дэлхий нийтийн жишгтэй нийцүүлснээр Монгол Улсын төр, засгаас хүний эрх, эрх чөлөөг хангах талаар явуулж буй бодлого, үйл ажиллагааг олон улсын тавцан дээр нотлон харуулах тэдний итгэлийг хүлээхэд зохих алхам болно.

в) Монгол Улсын иргэд гадаадад хувийн хэргээр зорчихоос гадна цагаачлах ивдэл бодит зүйс болоод байна. Гадаадад зорчиж, цагаачилж явах Монгол Улсын иргэдийн эрх зөрчилдөх, тэдний амьжиргааг хохирох ивдэл сүүлийн үед үзэгдэх болдоо. Тэрчлэн тус улсын иргэд чирэгдэл, саад бэрхшээл ч багасгүй тохиолдож байна. Иймд дээрх хуулийг баталн гаргаснаар амьдрал дээр гарч буй элдэв чирэгдэл, зорчлийг арилгаж, зорчих цагаачлахтай холбогдсон харилцааг зөвхөн хуулиар зохицуулах баталгаа бий болго.

Монгол Улсын иргэний гадаадад зорчих, цагаачлах эрхийг тодорхой шалтгаан, үндэслэлээр түдгэлзүүлж болно. Энэ нь хүний эрхийг зорчиж, хууль бусаар хязгаарлаж байгаа хэрэг биш юм, Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 18 дахь заалтаар «Зөвхөн хуулиар хязгаарлаж болно» гэснийг үндэслэн тогтоож буй түр хязгаарлалт болно.

Харин Монгол Улсын ирсэн гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх үндэслэл байгаа эсэхэд зөвхөн цагдаагийн байгууллага хяналт тавих бөгөөд үүнтэй холбогдсон гомдлоо иргэд шүүхэд гаргах эрх нь нээлттэй байгаа болно. Иргэдийн зорчих, цагаачлах эрхийг хуулиар хязгаарлах буюу түдгэлзүүлэхтэй холбогдон гарсан маргаантай саналын нэг нь өндөр зэрэгтэй, ховор, чухал мэргэжлийн хүмүүс гадаадад цагаачлах нь хүн амын эрүүл мэнд, үндэсний нийтлэг эрх ашигт хохирол үзүүлэхээр бол уг нөмцөл байдал арилтал түдгэлзүүлэх тухай асуудал байв. Улсын Их Хурал «Хүний эрхийг мэргэжил, дадлагатай холбоон хязгаарлах үндэсгүй бөгөөд тэдгээр хүмүүсийг нийтийн тусын тулд эх орондоо ажиглуулах шаардлагатай гэж үзвэл төр, засгаас давуутай нөхцөлөөр хангах, өөртэй нь зөвшилцөх замаар шийдвэрлэх ёстой» гэж үзэв.

Насанд хүрээгүй хүмүүс гадаадад зорчих, цагаачлах эрхтэй байх бөгөөд тэгэхдээ эцэг, эхтэйгээ хамт хууль ёсны асран хамгаалагч, хэргалзан дэмжигчийн хамт явах зарчмыг үндэс болгов. Насанд хүрээгүй иргэнд 16 хүртэл насны хүүхэд хамрах боловч 16—18 насны хүүхэд гадаадад цагаачлах тохиолдолд эцэг эх, асран хамгаалагчийн хамт явсан байх, тухайн хүүхдийн өөрийнх нь зөвшөөрлийг бичгээр заавал авсан

байхаар тогтоосон нь хүүхдийн эрхийн тухай олон улсын конвенцийн шаардлага болон манай орны олон нийтийн савнаа бодол, улс орны онцлогийг тусгасан зүйл гэж үзэж байгаа юм.

Улсын Их Хурлын гишүүн Т. СУЛТАН



---

**СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ:**

Ерөнхий зөвлөгч Н. Ринчиндорж  
Нарийн бичгийн дарга Сэн. Жаргалсайхан  
Гиншүх Т. Баянсүрэн  
Ч. Багуу

Техник редактор Т. Сарантуяа  
Угшиж хянасан Сэн. Жаргалсайхан  
Б. Ивжигалхам

Үйлдвэрт шилжүүлсэн 1994 оны 2-р сарын 3-нд  
Өрбөлд 1994 оны 2-р сарын 4-нд Хянагдвал  
1994 оны 2-р сарын 23-нд Хянагдвал туулж 5.0  
Хянасан тоо 3760

**Засгийн газрын хэвлэх үйлдвэр**